НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН

2024 оны 12 дугаар сарын 04-ний өдөр

| Д/д | | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв /сая төгрөг/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэтгэлийн Хувь | Үнэлгээ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **1 ДҮГЭЭР ХЭСЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ (23 Зорилт 57 арга хэмжээ)** | | | | | | | | | |
| **1.1. НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР, НИЙСЛЭЛИЙН ХӨГЖЛИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗААЛТУУДЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО (7 Зорилт 13 арга хэмжээ)** | | | | | | | | | |
| 1.1 | | **Зорилт 1.1 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.** (МУХТЖҮЧ 2.2.8 НХТЖҮЧ 2.10.1 НЗДҮАХ 2.1.5.1 ДЗДҮАХ 2.1.1) | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 90 | 90 ба түүнээс дээш | Эрүүл мэндийн төв тайлангийн хугацаанд нийт 42197 үзлэг хийснээс 18310 иргэнийг урьдчилан сэргийлэх үзлэгт, 20 төрлийн шинжилгээнд давхардсан тоогоор 9710 иргэнийг хамруулав. Нийт 18 нэр төрлийн 427,6 сая төгрөгийн өртөг бүхий тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, автомашинаар хангагдав. Эмч нарыг тогтвор суурьшилтай ажиллуулах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тасралтгүй түргэн шуурхай үзүүлэх зорилгоор дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны А/21 дүгээр тогтоолын дагуу Эрүүл мэндийн төвд үндсэн эмчээр ажиллах 6 хүртэлх эмчид орон нутгийн нэмэгдлийг нэмэлт 40 хувиар олгохоор санхүүжилт олгох гэрээ байгуулан ажиллаж байна. Уг гэрээний дагуу шалгуур хангасан 2 эмч үндсэн цалингийн 60 хувийн орон нутгийн нэмэгдэл авч байна. | 100 | 100 |
| 1. | 1.1.1 | **Арга хэмжээ - 1.1.1** Эрүүл мэндийн төвийн эмч, ажилчдын ур чадварыг үе шаттайгаар дээшлүүлэх | | Сургалтад хамрагдсан эмч, эмнэлгийн ажилтны тоо | 123 | 60 | Нийслэлийн ЭМГ-ын даргын 2024 оны А/37 дугаар тушаалаар “Багахангай Эрүүл мэндийн төв”-ийн дүрэм, бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн батлуулав. Эмч, эмнэлгийн ажилчдын мэдлэг ур | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | чадварыг дээшлүүлэх тасралтгүй сурах нөхцөлийг бүрдүүлж дотоодын сургалтыг 32 удаа зохион байгуулж 67, ЭМЯ, НЭМГ, НЭМҮТ-өөс зохион байгуулсан 69 удаагийн сургалтад давхардсан тоогоор 73 эмч, эмнэлгийн ажилтныг хамруулав. Тайлангийн хугацаанд байнгын ажлын байраар 7, түр ажлын байранд 1, гэрээгээр 2 эмч, эмнэлгийн ажилтныг томилон ажиллуулж байна. Мөн мэргэжил дээшлүүлэх сургуульд туслах сувилагч-2, сувилагч-1, их эмч-1, эмнэлгийн мэргэжилтэн-1 нийт 4 ажилтан суралцаж байна. | | |
| 2. | 1.1.2 | **Арга хэмжээ - 1.1.2** Зайлшгүй шаардлагатай эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлэх | 10,0 | Хангагдсан тоног төхөөрөмжийн тоо | 11 | 3 | Эрүүл мэндийн төв эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор 16 нэр төрлийн багаж төхөөрөмжийг шинэчлэн 6,7 сая төгрөг зарцуулав. Мөн МУЗГ-ын гишүүн, Шадар сайд, УИХ гишүүн С.Амарсайхан яаралтай тусламжийн бэлэн байдлыг хангах ажлын хүрээнд амьсгалын аппараттай бүрэн тоноглогдсон 413,8 сая төгрөгийн өртөг бүхий автомашин, Дэээрэт ОУБ-аас 7,1 сая төгрөгийн өртөг бүхий нярайн шарлалтыг эмчлэх фото аппарат, шар хэмжих билиметр тус тус нийлүүлээд байна. | 100 | 100 |
| 3. | 1.1.3 | **Арга хэмжээ - 1.1.3** Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдах иргэдийн тоог нэмэгдүүлэх | | Урьдчилан сэргийлэх эрт илрүүлэгт хамрагдалтын хувь | 46,2 | 70 | “Бүтээмж-Хамтын ажиллагааг дээшлүүлэх зорилтот жил”-ийн хүрээнд урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгт хамрагдалтыг нэмэгдүүлэх зорилгоор фокус бүлгийн уулзалтыг 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр зохион байгуулж 6 байгууллагын удирдлага оролцож 2024/09 тоот хамтран ажиллах гэрээ байгуулав. Гэрээг хэрэгжүүлэх 17 заалт бүхий төлөвлөгөө гарган эрт илрүүлэгт хамрагдах нөлөөллийн ажил зохион байгуулав. Эрт илрүүлгийн үзлэгт | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хамрагдвал зохих 4463 иргэнээс 2814 иргэнийг Эрүүл мэндийн төвд хамруулж хамрагдалт 63,0, Улаанбаатар хот болон бусад орон нутагт дүүргийн харьяалалтай 319 иргэн хамрагдаж 7,1 нийт дүүргийн хэмжээнд эрт илрүүлэгт хамрагдалт 70,1 хувь байна. Эрт илрүүлэг үзлэгийн үр дүнд хавдрын сэжигтэй 21 хүнийг лавлагаа шатны эмнэлэгт илгээсэн ба шинээр 6 хавдар оношлогдож эмчлэгдэж байна. | | |
| 2.2 | | **Зорилт 2.2 Нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх** (МУХТЖҮЧ 3.5.3<br>ЗГҮАХ 2.2.1<br>НХТЖҮЧ 3.5.3<br>НЗДҮАХ 2.2.1<br>ДЗДҮАХ 2.2.1) | - | Арга хэмжээний хэрэгжилт, дундаж хувь | 90 | 91 | Нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх орчин нөхцөлийг сайжруулахад 1,203,9 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэв. Дүүргийн БТСХороо нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх чиглэлээр 10 заалт бүхий төлөвлөгөө гарган хөнгөн атлетик суурьтай 18 төрлийн арга хэмжээг зохион байгуулж давхардсан тоогоор 260 байгууллагын 9224 ажилтан албан хаагч, иргэд оролцож 10,7 сая төгрөг зарцуулав. | 100 | 100 |
| 4. | 2.1.1 | **Арга хэмжээ - 2.1.1** Иргэдийг нийтийн биеийн тамир спортоор хичээллэх нөхцөл боломжоор хангах, тэмцээн уралдаан зохион байгуулах | | Хамрагдсан иргэдийн тоо | 1200 | 1500 | БТСХ иргэдийн биеийн тамир спортоор хичээллэх нөхцөл боломжийг бүрдүүлэн 9 ААНБ-тай гэрээ байгуулж 7 хоног бүр 2 цаг спорт заалаар үйлчилж байна. Дүүргийн ААНБ-уудын ажилтан, албан хаагчид, иргэдэд чиглэсэн “Дасгал хийж хамтдаа хөгжье”, “Алхацгаая, гүйцгээе”, “Эрүүл, идэвхтэй Багахангайчууд-2024”, “Илүүдэл жингүй - Эртэч Багахангайчууд”, “Адар баян” өвлийн 100 км-ын явган алхалт зэрэг 9 арга хэмжээг зохион байгуулж давхардсан тоогоор 215 байгууллагын 8025 ажилтан, албан хаагч, иргэд оролцсон байна. Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг Нийслэлийн Иргэдийн спортын их наадмын анхан шатны тэмцээнийг дүүрэгт 6 төрлөөр зохион байгуулж нийт 225 тамирчин оролцож 2,5 сая төгрөгийг зарцуулан ба Нийслэлийн аварга шалгаруулах тэмцээнд | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Явган алхалт, Волейбол, Ширээний шагайн наадгайн төрөлд эрэгтэй, эмэгтэй багийн 54 тамирчид оролцсоноос Шагайн наадгай төрөлд эрэгтэй, эмэгтэй баг Алтан медаль хүртээд байна. Дүүргийн БТСХороо нь мэргэжлийн 12 спортын холбоодтой хамтран ажиллаж байна. Тайлангийн хугацаанд улс бүсийн чанартай 3 төрлийн тэмцээнийг зохион байгуулан 920 тамирчин оролцож 8,4 сая төгрөг зарцуулав. | | |
| 5. | 2.1.2 | **Арга хэмжээ - 2.1.2** Иргэдэд үйлчлэх биеийн тамир, спортын стандартын шаардлага хангасан зал, талбайн хэмжээг нэмэгдүүлэх | 1,1 тэрбум | 2-р хорооны заалыг ашиглалтад оруулах | 70 | 100 | Дүүргийн хэмжээнд БТСХ-ны 1, ЕБС-ийн 2 нийт 3 заал үйл ажиллагаа явуулж байна. Спорт заалаар давхардсан тоогоор 13580 иргэн үйлчлүүлсэн байна. Дүүрэгт Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2,415,0 сая төгрөгөөр 2 дугаар хорооны стандартын шаардлага хангасан спорт заалыг он дамжин барьж байгаа бөгөөд энэ оны төсөвт 1,1 тэрбум төгрөг суугдаж ажлыг 05 дугаар сараас эхэлсэн ба гүйцэтгэгч Алтайн шар говь ХХК 2024 оны 12 дугаар сард хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна. Мөн 1-р хорооны Үнэгтэй гэр хороололд Улаанбаатар хотын ЗАА-аас 103,9 сая төгрөгийн өртөг бүхий 3х3 сагсан бөмбөгийн стандартын шаардлага хангасан талбайг байгуулж ашиглалтад хүлээн аваад байна. | 90 | 70 |
| 2.3 | | **Зорилт 2.3** Боловсролын байгууллагын чанар хүртээмжийг нэмэгдүүлэн, сургалтын таатай орчныг бүрдүүлнэ. (МУХТЖҮЧ 2.1.8 ДЗДҮАХ 2.3.3) | | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 90 | 90 ба түүнээс дээш | Тайлангийн хугацаанд боловсролын байгууллагын сургалтын таатай орчныг бүрдүүлэхэд 1,125,6 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж, 132 багшийн ур чадварыг нэмэгдүүлэх, чадавхжуулах сургалтад хамруулав. | 100 | 100 |
| 6. | 2.3.1 | **Арга хэмжээ - 2.3.1** Багшийн ур чадварын | | Сургалтад хамрагдсан | 117 | 100-аас дээш | Багшийн мэргэжил дээшлүүлэх 1,5,10 жилийн үндсэн сургалтад ЕБС-ийн 14, | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | түвшинг дээшлүүлнэ. | | багш | | | СӨББ-ын 4 багш хамрагдаж батламж авав. Нийслэлийн Боловсролын газрын APLUS модуль цахим сургалтад ЕБС-ийн 43, СӨББ-ын 28, СӨББ-ын Бэлтгэл бүлгийн багш нарын сургалтад 3, бага боловсролын болон математикийн EDUTEN сургалтад 17, Англи хэлний PEARSON хөтөлбөрийн сургалтад 4 багш хамрагдаж мэдлэг чадвараа хөгжүүлэн ажиллаж байна. Мөн 19 судлагдахууны багш нар НБГ-аас гаргасан графикт сургалтад хуваарийн дагуу тухай бүр хамрагдаж байна. Жил бүр зохион байгуулагддаг “Багшийн мэргэжлийн ур чадварын тэмцээн”-д ЕБС-ийн 8, СӨББ-ийн 2 нийт 10 багш оролцож 1 багш Тэргүүн байр, 7 багш Тусгай байранд шалгарав. 2023-2024 оны хичээлийн жилийн гүйцэтгэлийн үнэлгээнд ЕБС-ийн 33 багш, 823 сурагч, СӨББ-ын гүйцэтгэлийн үнэлгээнд үнэлгээнд 10 багш, 177 хүүхэд хамрагдлаа. 2024 оны индексийн урамшуулалд 207 дугаар цэцэрлэг нь Нийслэлийн шилдэг менежмэнттэй Ментор цэцэрлэгээр шалгарлаа. | | |
| 7. | 2.3.2 | **Арга хэмжээ - 2.3.2** Хүүхэд багачуудын сурч боловсрох таатай орчин, өөрийгөө нээн хөгжүүлэх боломж нөхцлийг бүрдүүлнэ | 819,4 | Хөрөнгө оруулалтын хэмжээ | 1,000 | 819,4 | Тайлангийн хугацаанд боловсролын байгууллагын сургалтын таатай орчныг бүрдүүлэхэд 1,125,6 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэв.<br>Хүүхэд багачуудын сурч боловсрох, өөрийгөө нээн хөгжүүлэх боломж нөхцөлийг хангах зорилгоор дүүрэгт нийт 36 төрлийн дугуйлан секцэд давхардсан тоогоор 713 хүүхэд багачууд хамрагдаж байна. Соёлын ордны дугуйлангийн сурагчдын “Аз жаргалтай хүүхдүүд” тоглолтыг зохион байгуулав. | 100 | 100 |
| 2.4 | | **Зорилт 2.4** Нийгмийн халамжийн зорилтот | | Үйл ажиллагаан | 90 | 90 ба түүнээс | Ажил хөдөлмөр эрхэлдэггүй, нийгмийн халамжид хамрагддаггүй зорилтот бүлгийн | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | бүлгийн иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлнэ. (МУХТЖҮЧ 2.3.4<br>ЗГҮАХ 2.5.8, 2.5.9<br>НХТЖҮЧ 3.1.1, 3.2.1, НЗДҮАХ 2.4.1, 2.4.2, ХАХТ 2.4.1.2, 2.4.2.1, ДЗДҮАХ 2.4.1, 2.4.2, 2.4.3) | | ы хэрэгжилт, хувь | | дээш хувь | 6 иргэнийг нийгмийн хамгааллын суурь үйлчилгээнд хамруулж 2,0 сая төгрөг, Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд 46 өрхийн 249 иргэнийг хамруулан 31,6 сая төгрөг, зарцуулав. | | |
| 8. | 2.4.1 | **Арга хэмжээ - 2.4.1** Дүүргийн хүүхэд, ахмад настан, тусгай хэрэгцээт (хөгжлийн бэрхшээлтэй) болон амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой иргэдэд нийгмийн халамжийн үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэх | 60,0 | Хамрагдсан хүний тоо | 3532 | 3000-аас дээш | Ахмад настны дэмжлэг, тусламж, хөнгөлөлтөд 644 иргэнийг хамруулж 73,0 сая, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт, тусламжид 66 иргэнийг хамруулан 11,3 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.<br>Тайлангийн хугацаанд нийгмийн халамжийн үйлчилгээнд нийт 3564 иргэнийг хамруулж 3,1 тэрбум төгрөг зарцуулсан бол Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний хамт олны бүлэг бүрдүүлэн төсөл хэрэгжүүлж орлогын эх үүсвэртэй болоход нь дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд 4 бүлгийн 8 өрхийн гишүүнийг хамруулан 10,0 сая төгрөгийн санхүүжилт олгов. | 100 | 100 |
| 2.5 | | **Зорилт 2.5** Хөдөлмөр эрхлэлтийг дэмжин зорилтот бүлгийн иргэдийн ажлын байрыг нэмэгдүүлнэ. (МУХТЖҮЧ 2.3.4, ЗГҮАХ 2.5.8, ДЗДҮАХ 2.5.2, 2.5.3) | | Үйл ажиллагаан ы хэрэгжилт, хувь | 90 | 90 ба түүнээс дээш хувь | “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” чиглэлээр 2024 онд хийж хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний төлөвлөгөөг 11 заалттайгаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төлөвлөгөөний хүрээнд 15 аж ахуйн нэгж байгууллагаас давхардсан тоогоор 140 ажлын байрны захиалга авч байнгын ажлын байранд 89, түр ажлын байранд15 иргэн зуучлагдсан ба өөрөө өөртөө ажлын байр бий болгох, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэгт нийт 24 иргэнд 250,0 сая төгрөгийн санхүүжилт олгов. | 100 | 100 |
| | 2.5.1 | **Арга хэмжээ - 2.5.1** | 29,1 | Хамрагдсан | 54 | 80-аас | Ажилгүйдэлд бүртгэлтэй, орлого багатай | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Зорилтот бүлгийн иргэдийн ажлын байрыг нэмэгдүүлэх, төсөл хөтөлбөрт хамруулах | | иргэдийн тоо | | дээш | иргэнийг түр ажлын байраар ханган өрхийн орлогыг нь нэмэгдүүлэх зорилгоор хороодоос ирүүлсэн төсөл, төлөвлөгөөний дагуу нийтийг хамарсан ажилд 60 иргэнийг хамруулж 24,0 сая төгрөгийг урамшуулалд зарцуулсан байна. | | |
| 9. | 2.5.2 | **Арга хэмжээ – 2.5.2** Ахмад настны мэргэжлийн ур чадвар, ажлын туршлагад суурилсан зөвлөн туслах, үйлчилгээнд хамрагдагсдын тоог нэмэгдүүлэх | 36,0 | Хамрагдсан ахмад настны тоо | 6 | 10-аас дээш, | Тайлангийн хугацаанд Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд 8 ахмад настныг хамруулан 8,6, “Хүүхэд хамгаалагч” арга хэмжээнд 2 ахмад настныг хамруулж, 2,6 сая төгрөгийг урамшуулалд зарцуулсан байна. Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт 6 ахмадыг хамруулж 48,0 сая төгрөг олгов. | 100 | 100 |
| 2.6 | | **Зорилт 2.6** Соёл, урлагийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ. (ЗГҮАХ 2.6.3.6, НЗДҮАХ 2.6.4, НХТЖҮЧ 1.1.2, ДЗДҮАХ 2.6.2, 2.6.3) | | Үйл ажиллагаан ы хэрэгжилт, хувь | 90 | 90 ба түүнээс дээш хувь | Дүүргийн хэмжээнд 2024 онд соёлын чиглэлээр зохион байгуулах ажил, арга хэмжээний төлөвлөгөөг 10 заалттайгаар боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллав.<br>Тайлангийн хугацаанд урлагийн тоглолт 26, хурал цуглаан, сургалт 34, кино үзвэр 6, номын сангийн үйлчилгээ 869 удаа буюу нийт 935 соёл урлагийн олон талт үйл ажиллагаа явуулж давхардсан тоогоор 16900 гаруй иргэн хамрагдсан байна.<br>2024 онд "Силикон арт дизайн" ХХК тендерт шалгарч Нийслэлийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 67,0 сая төгрөг бүхий орчин үеийн стандартын шаардлага хангасан 24 нэр төрлийн 75 ширхэг үндэсний болон цахилгаан хөгжим техник хэрэгслээр хангагдав. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2024 оны 09 дүгээр “Морин хуурыг эрхэмлэн дээдэлж түгээн дэлгэрүүлэх тухай” зарлигийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Соёлын яам, НСУГ-аас 3,0 сая төгрөгийн өртөг бүхий 5 ширхэг мастер морин хуур хүлээн авав. | 100 | 100 |
| 10. | 2.6.1 | **Арга хэмжээ – 2.6.1** | 2,0 | Хамтран | 3 | 2-оос дээш | “Бүтээмж-Хамтын ажиллагааг дээшлүүлэх | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Хүүхэд залуучууд, иргэдийг хотын соёлд суралцуулах мэргэжлийн байгууллагатай хамтран соёлын олон талт арга хэмжээг зохион байгуулна. | | ажилласан байгууллага<br><br>Зохион байгуулсан арга хэмжээ | 4 | байгууллагатай хамран ажиллана<br><br>3-аас дээш арга хэмжээ зохион байгуулна | зорилтот жил"-ийн хүрээнд хүүхэд залуучууд, иргэдийг хотын соёлд суралцуулах зорилгоор "Нэг хот-нэг гэр бүл", "1000-0", "Нэг зам-нэг соёл", "Соёл танаас эхэлнэ" зэрэг 8 нөлөөллийн аян, арга хэмжээг зохион байгуулав.<br>Дүүрэг үүсэн байгуулагдсаны 35 жилийн ойг угтан "The Open mic Mongolia"-тай хамтран "Bagakhangai Open mic" арга хэмжээ, дүүргийн Соёлын ордны мэргэжлийн уран бүтээлчдийн "Бүсгүйчүүд" тоглолт, Соёлын ордны уран бүтээлчид болон БНСУ-ын уран бүтээлчдийн хамтарсан тоглолт, Төв аймгийн "Монгол туургатан" театрын уран бүтээлчид, СУИС-ийн Бүжгийн урлагийн тэнхимтэй хамтран 4 удаагийн тоглолт зохион байгуулж 1020 иргэн үзэж сонирхов. "Соёлын бүтээлч сар-2024" аяны хүрээнд Улаанбаатар театр"-ын уран бүтээлчдийн тоглолтыг зохион байгуулж 140 гаруй иргэдэд соёлын үйлчилгээг хүргэв. | | |
| 2.7 | | **Зорилт 2.7** Гэр бүлийн тогтвортой байдлыг хангана. (ЗГҮАХ 4.2.7, НХТЖҮЧ 2.12.1, НЗДҮАХ 2.7.1, ХАХТ 2.7.1.2, ДЗДҮАХ 2.7.1, 2.8.1) | | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 90 | 90 ба түүнээс дээш | Гэр бүлийн боловсрол олгох сургалтын хөтөлбөрийн дагуу 8 агуулгын хүрээнд 23 удаагийн сургалтыг давхардсан тоогоор 1249 иргэнд зохион байгуулж цахим сайт болон фэйсбүүк хуудсаар түгээн 1600 гаруй хүний хандалт авсан байна. Гэр бүлийн хөгжлийг дэмжих чиглэлээр 10 төрлийн мэдээллийг цахим хуудсаар түгээн 530 хүний хандалт авсан байна.<br>"Гэр бүлийн өдөр" арга хэмжээг 5 удаа зохион байгуулав. Дүүргийн 27 аж ахуйн нэгж байгууллагад чиглэл хүргүүлж давхардсан тоогоор 9 төрлийн үйл ажиллагаа зохион байгуулж, 190 иргэн, 84 хүүхэд, зорилтот бүлгийн 20 өрхийг хамрууллаа. | 100 | 100 |
| 11. | 2.7.1 | **Арга хэмжээ – 2.7.1** | | Зохион | 15 | 10 ба | ХНХСайдын 2019 оны А/122 тоот | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Гэр бүлийн гишүүн бүрт чиглэсэн сургалт сурталчилгаа, нөлөөллийн ажил зохион байгуулж, гэр бүлд үзүүлэх хамгааллын үйлчилгээг сайжруулна. | | байгуулсан арга хэмжээний тоо<br><br>Хамрагдсан хүний тоо | 570 | түүнээс дээш<br><br>250-аас дээш хүн | тушаалаар батлагдсан Гэр бүлийн боловсрол олгох сургалтын хөтөлбөрийн бүтэц, 8 агуулгын хүрээнд давхардсан тоогоор 23 удаагийн сургалтыг 1249 иргэнд зохион байгуулсан байна.<br>ХГБХХХ нь Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх танхимын сургалтыг 3 удаа зохион байгуулж, туршилтын хөтөлбөрт хамрагдаж буй 40 өрхийн 56 иргэн, архи хэтрүүлэн хэрэглэдэг 31 иргэн, зорилтот бүлгийн 209 иргэнийг хамруулав.<br>ХТУ-108 төвд 9 дуудлага ирснээс бие махбодын хүчирхийлэл 2, үл хайхрах хүчирхийлэл 3, бэлгийн шинжтэй үйлдэл 1, худал мэдээлэл 3 нийт дуудлагад хамаарах хүүхдийн тоо 3-15 насны 10 хүүхэд байна.<br>“Хүүхэд хамгааллын аян”-ны хүрээнд улирал бүр илрүүлэлт арга хэмжээг Цагдаагийн хэлтэс, ХГБХХХ хамтран 4 удаа, гэнэтийн хяналт шалгалтыг 2 удаа зохион байгуулж, уяачид, эцэг эх, асран хамгаалагчдад зөвлөгөө мэдээлэл хүргэв. Хурдан морины 11 жүчээ, төмөр замын 1 өртөө, 8 зөрлөг, үйлдвэрийн бүс зэрэг эрсдэлтэй 4 үйлдвэрээр явж зөвлөмж өгч уралдаанч хүүхэд 22, туслах уяач 8, уяач 19 иргэнийг бүртгэж хяналтад авлаа. 2023 оны мөн үетэй харьцуулахад жүчээнд морь унаж буй хүүхдийн тоо 45.4 хувиар өссөн байна. Хараа хяналтгүй, хөдөлмөр эрхэлдэг, эрхлэх эрсдэлтэй хүүхэд илрээгүй. Хараа хяналт сул, үл хайхрах хүчирхийлэлд өртсөн 1 хүүхдийг түр хамгаалах байранд хүлээн авч хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлж, эрсдэлийг бууруулан ар гэрт нь эрген нэгтгэв.<br>Зорилтот жилийн хүрээнд хороодын “Хамтарсан баг”-ийн үйл ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор Фокус ярилцлага, | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | уулзалтыг зохион байгуулж 2024/19 хамтран ажиллах гэрээ байгуулан 30 заалт бүхий төлөвлөгөө гарган ажиллав.<br>Хамтарсан баг 6 удаагийн хурлыг зохион байгуулж 10 кейсийг нээн холбогдох үйлчилгээг үзүүлсэн байна. ХГБХХХ-тэй хамтран ажилладаг сэтгэлзүйч 15 гэр бүлд хууль эрх зүй, сэтгэл зүйн зөвлөгөө, ХГБХХХ-ээс Хамтарсан багт 3 удаа мэргэжил арга зүйн зөвлөгөө тус тус өгөв. | | |
| 12. | 2.7.2 | **Арга хэмжээ -2.7.2**<br>“Жендэрийн эрх тэгш байдлыг хангах” дүүргийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулна. | | Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь | 95% | 95 ба түүнээс дээш хувь | “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөр”-ийн хүрээнд 6 арга хэмжээг зохион байгуулж иргэдийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор 5 төрлийн мэдээлэл, шторкыг 12 ААНБ-ын фейсбүүк цахим хуудас болон сайтад байршуулан 1321 орчим хүний хандалт авсан байна.<br>Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэхээр 2024 оны төлөвлөгөөг 4 бүлэг 34 заалттайгаар боловсруулан хэрэгжилтийг хангав. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах төрийн бодлого, хууль тогтоомжийг аж ахуйн нэгж байгууллага, олон нийтэд таниулах, сурталчлах, хэвшмэл ойлголт хандлагыг өөрчлөх зорилгоор “Харилцан хүндэтгэе” аяныг “Харилцан хүндэтгэж тэгш оролцоог хангая” уриан дор тэмдэглэн өнгөрүүлж гуравдугаар сарын “Гэр бүлийн өдөр” арга хэмжээг “Харилцан хүндэтгэе” сэдвийн хүрээнд зохион байгуулав. Аяны хүрээнд 11 ААНБ-д “Жендэрийн тухай ойлголт” сэдэвт сургалт зохион байгуулж 180 иргэн, “Хангай” сургуулийн 6-8-р ангийн 150 сурагчдад “Харилцан хүндэтгэе” сургалтыг тус тус зохион байгуулав.<br>Дүүргийн 8 удирдах ажилтан “Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт” сургалтад | 100 | 90 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хамрагдан, асуудал хариуцсан мэргэжилтэн чадавхжуулах сургалтад хамрагдав.<br>Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аяныг 11 дүгээр сарын 25-наас 12 дугаар сарын 10-ны өдрийн хооронд “Охид, эмэгтэйчүүд хаана ч аюулгүй-Шалтаг бүү тооч” уриан дор зохион байгуулж байна. Уг аянд дүүргээс 8 ААНБ нэгдэн өөрийн фэйсбүүк цахим хуудсанд аяны постер мэдээллийг байршуулан 150 гаруй хүний хандалт аваад байна. | | |
| **ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР** | | | | | | | | | |
| **ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО ( 8 зорилт 14 арга хэмжээ)** | | | | | | | | | |
| 2.1 | | **Зорилт 2.1.** Нийслэлийн төсвийн бус санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.<br>НХТЖҮЧ-4.1.1<br>НЗДҮАХ-3.1.1.3<br>ДЗДҮАХ- | - | Үйл ажиллагаан ы хэрэгжилт, хувь | 90 | 90 ба түүнээс дээш | Нийслэл, дүүргийн өмчийг зах зээлийн бодит үнэлгээгээр иргэн, аж ахуйн нэгжүүдэд түрээслүүлж, өөрийн орлогыг нэмэгдүүлэн төсөвт төвлөрөх орлогыг 16.7 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн. Газрын төлбөр өссөн дүнгээр 56.8 сая, Үл хөдлөх хөрөнгийн албан татварт 61.5 сая төгрөг төвлөрүүлж гүйцэтгэл 155.6 хувьтай биелсэн.<br>2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн байдлаар:<br>- Улсын төсвийн орлого өссөн дүнгээр 1,458.8 сая төгрөг төвлөрүүлэхээс 1,913.3 сая төгрөг төвлөрүүлж 131.1 хувьтай,<br>- Нийслэлийн төсөвт өссөн дүнгээр 92,4 сая төгрөг төвлөрүүлэхээс 57,9 сая төгрөг буюу төлөвлөгөөний биелэлт 62.7 хувьтай,<br>- Дүүргийн төсөвт өссөн дүнгээр 1,325.6 сая төгрөг төвлөрүүлэхээс 1,860.9 сая төгрөг төвлөрүүлж 140.4 хувьтай тус тус биелсэн байна. | 100 | 100 |
| 13. | 2.1.1 | **Арга хэмжээ - 2.1.1**<br>Нийслэл, дүүргийн | - | Түрээсийн орлого, | 17.5 сая төгрөг | 21.8 сая төгрөг | Дүүргийн Засаг даргын Тамгын газар нь нийслэл, дүүргийн өмчийн байрыг 4 аж | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | өмчийг зах зээлийн бодит үнэлгээгээр иргэн, аж ахуйн нэгжүүдэд түрээслүүлж, төсөвт төвлөрөх орлогыг нэмэгдүүлнэ. | | сая төгрөг | | | ахуйн нэгжид зах зээлийн бодит үнэлгээг үндэслэн түрээслүүлж, төсөвт 11,0 сая, үндсэн үйл ажиллагааны орлогоор Худалдан авах ажиллагааны алба 1,9 сая төгрөг, Дотоод аудитын алба 1,7 сая төгрөг, Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төв 1.5 сая төгрөг, Соёлын ордон 7,0 сая төгрөг нийт 39.8 сая төгрөг төвлөрүүлэв. Дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй Багахангай тохижилт, Гэрэлтүүлэг, ногоон байгууламж, Илч-Орд гэсэн 3 ОНӨААТҮГ 16.7 сая төгрөгийн ажил үйлчилгээний орлого төвлөрүүлж төсвийн орлогыг нэмэгдүүлсэн. | | |
| 14. | 2.1.2 | **Арга хэмжээ - 2.1.2** Нийслэл, дүүргийн хэмжээнд газар, үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийг сайжруулж, татварт хамрагдалтыг нэмэгдүүлэх, | - | Төсөвт төвлөрүүлэх газар, үл хөдлөх эд хөрөнгийн орлого, сая төгрөг | Газрын төлбөрт 103.7 сая, үл хөдлөх эд хөрөнгийн татварт 53.1 сая төгрөг | Газрын төлбөрт 62.4 сая, үл хөдлөх эд хөрөнгийн татварт 40.0 сая төгрөг | 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн байдлаар Газрын төлбөр өссөн дүнгээр 56,8 сая төгрөг төвлөрүүлэхээс 79,2 сая төгрөг төсөвт төвлөрүүлэн төлөвлөгөө 136.4 хувьтай, Үл хөдлөх хөрөнгийн албан татвар төлөвлөгөөгөөр 35,8 сая төгрөг төвлөрүүлэхээс 61,5 сая төгрөг төвлөрүүлж гүйцэтгэл 171,8 хувьтай биелсэн байна. | 100 | 100 |
| 15. | 2.1.3 | **Арга хэмжээ - 2.1.3** Улс, нийслэл, дүүргийн татварын орлогын төлөвлөгөөг биелүүлэх | - | Төсөвт төвлөрүүлэх орлого, сая төгрөг | Улсын төсвийн орлого 1,698.2 сая төгрөг, Нийслэлийн төсвийн орлого 101.9 сая төгрөг, Орон нутгийн | Улсын төсвийн орлого 2,152.3 сая төгрөг, Нийслэлийн төсвийн орлого 94.7 сая төгрөг, Орон нутгийн төсвийн орлого | 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн байдлаар:<br>- Улсын төсвийн орлого өссөн дүнгээр 1,458.8 сая төгрөг төвлөрүүлэхээс 1,913.3 сая төгрөг төвлөрүүлж 131.1 хувьтай,<br>- Нийслэлийн төсөвт өссөн дүнгээр 92,4 сая төгрөг төвлөрүүлэхээс 57,9 сая төгрөг буюу төлөвлөгөөний биелэлт 62.7 хувьтай,<br>- Дүүргийн төсөвт өссөн дүнгээр 1,325.6 сая төгрөг төвлөрүүлэхээс 1,860.9 сая төгрөг төвлөрүүлж 140.4 хувьтай тус тус биелсэн байна. | 90 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | төсвийн орлого 1,162.1 сая төгрөг, Нийт татварын орлого 2,962.3 сая төгрөг | 1,769.0 сая төгрөг, Нийт татварын орлого 4,016.0 сая төгрөг | | | |
| 2.2 | | **Зорилт - 2.2** Орон нутгийн хөгжлийн сан, дүүргийн төсвийг иргэдэд нээлттэй мэдээлэх, иргэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх. НЗДҮАХ-ХАХТ-4.1.1.2 ДЗДҮАХ 3.1.3 | - | Үйл ажиллагаан ы хэрэгжилт, хувь | 90 | 90 ба түүнээс дээш хувь | Улс, нийслэл, ОНХС, төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 137 төсөл хөтөлбөр, арга хэмжээний талаар 1500 ширхэг товхимол гарган 1, 2 дугаар хороодоор дамжуулан иргэдэд хүргэв. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон холбогдох журам, заавар шинэчлэн батлагдсантай холбогдуулан дүүргийн удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнд 1 удаа танилцуулга хийв. А3 гэрчилгээтэй 35 албан хаагч, иргэдийн төлөөлөлд сургалт зохион байгууллаа. | 100 | 100 |
| 16. | | **Арга хэмжээ - 2.1.1** Орон нутгийн сангаас санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг иргэдээс цахим хэлбэрээр буюу гар утасны апликейшн ашглан авах. | - | Цахимаар санал өгсөн иргэд, хувь | 50% | 70% | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хэрэгжих төсөл хөтөлбөр арга хэмжээний саналд 4 ажлын саналыг хүргүүлээд байна. Нийслэл болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээнд иргэдээс цахим санал, асуулга авах ажлыг 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс 2024 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн хооронд зохион байгуулав. Цахим санал асуулгад 2710 иргэн хамрагдахаас 1833 иргэн санал өгч 68%-тай оролцлоо. ОНХС-гийн санал асуулгыг идэвхжүүлэх зорилгоор дүүргийн Засаг даргын А/99 дугаар захирамжаар 580,600 | 70 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | төгрөгийн хөрөнгө гарган ажилласан.<br>2025 онд дараах ажлыг хэрэгжүүлэхээр иргэдээс санал авсан. Үүнд:<br>- Үерийн далан суваг шуудуу засварлах,<br>- Гэр хороолол болон шинэ суурьшлын бүсэд цахилгаан хангамж нэмэгдүүлэх,<br>- Тохижилт, засвар үйлчилгээ,<br>- Гэрэлтүүлэг,<br>- Автомашины зогсоол байгуулах,<br>- Камержуулалт,<br>- 1, 2 дугаар хороог холбосон ногоон байгууламж нэмэгдүүлэх зэрэг болно. | | |
| 17. | | **Арга хэмжээ - 2.1.2**<br>Үнэлгээний хороонд иргэдийн төлөөллийг томилох, хөрөнгө оруулалтаар хийгдэж буй ажлын явцад хяналт тавих комиссын бүрэлдэхүүнд иргэдийн төлөөллийг оруулж оролцоог нэмэгдүүлэх | - | Үнэлгээний хороо болон Комиссын бүрэлдэхүүнд орсон иргэдийн тоо, хувь | Давхардсан тоогоор 33 иргэн | 20 иргэн | Худалдан авах ажлын төлөвлөгөөг 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдөр төлөвлөгөөг батлан Сангийн яаманд хүргүүлсэн. Худалдан авах төлөвлөгөөний 37 үнэлгээний хороо байгуулж давхардсан тоогоор 185 албан хаагч, иргэн ажиллав. Үнэлгээний хорооны гишүүдээр “Ашиг сонирхолын мэдүүлэг” бөглүүлэн shilendans.gov.mn, tender.gov.mn болон бусад мэдээллийн сувгуудаар ил тод нээлттэй мэдээллэж байна. | 100 | 100 |
| 18. | | **Арга хэмжээ - 2.1.3**<br>2022 онд хэрэгжиж дууссан, он дамжин хэрэгжиж буй ажлууд болон 2023 онд хэрэгжих хөрөнгө оруулалтын ажлын талаар танилцуулга, гарын авлага бэлтгэж иргэдэд хүргэх ажлыг зохион байгуулах. | - | Гарын авлагын тоо, хувь | 150 ширхэг гарын авлага | 150 ширхэг гарын авлага | Улс, нийслэл, ОНХС, төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 137 төсөл хөтөлбөр, арга хэмжээний талаар 1500 ширхэг зурагт танилцуулга бэлтгэн 1, 2 дугаар хороодоор дамжуулан иргэдэд хүргэв. | 100 | 100 |
| | 2.3 | **Зорилт - 2.3**<br>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр хэрэгжүүлэх, төсөл, арга хэмжээний худалдан авах үйл | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 90 | 90 ба түүнээс дээш хувь | Дүүргийн төсвийн хөрөнгө, Орон нутгийн хөгжлийн сан, Нийслэлийн Засаг даргаас эрх шилжин ирсэн ажлын тендер шалгаруулалтад оролцсон компаниудад ТБОНӨБАУХА тухай хуулийн дагуу гүйцэтгэгчээр шалгарсан тухай мэдэгдлийг | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | ажиллагааны сонгон шалгаруулалтыг ил тод болгож, үр дүнтэй зарцуулах.<br>ДЗДҮАХ-3.1.4 | | | | | 33 байгууллага, шалгараагүй мэдэгдлийг 30 байгууллагад хүргүүлэв.<br>Мөн tender.gov.mn, shilendans.gov.mn сайтад тухай бүр тендер шалгаруулалтын үр дүнгийн талаар мэдээллийг байршуулсан. | | |
| 19. | | **Арга хэмжээ - 2.3.1**<br>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг холбогдох журмын дагуу 100 хувь цахим системээр зохион байгуулж, тендер шалгаруулалтын үр дүнг /tender.gov.mn/ цахим системд ил тод нийтэлсэн байх. | - | Хөрөнгө оруулалтын ажлын тоо, хувь | 14 ажил | 8 ажил | Төрийн Худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/-д 2024 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хуулийн хугацаанд шивж баталгаажуулан хэрэгжилтийг ханган ажиллав. Нийт 37 төсөл хөтөлбөр арга хэмжээ хэрэгжихээр төлөвлөгдсөнөөс нээлттэй тендер шалгаруулалтын журмаар-10, шууд худалдан авалтаар-18, харьцуулалтын аргаар- 8, ерөнхий гэрээний журмаар-1 бараа, ажил, үйлчилгээ батлагдсан байна. Жилийн эцсийн байдлаар 19 бараа, ажил, үйлчилгээний тендер шалгаруулалтыг төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр, 17 ажлын сонгон шалгаруулалтыг шууд худалдан авах аргаар зохион байгуулав. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу гүйцэтгэгчээр шалгарсан тухай мэдэгдлийг 33, шалгараагүй мэдэгдлийг 30 байгууллагад хүргүүлэн tender.gov.mn, shilendans.gov.mn сайтад тендер шалгаруулалтын үр дүнгийн талаарх мэдээллийг тухай бүрт байршуулав. Үр дүн гараагүй тендер шалгаруулалтын шатандаа 4 ажил байна. Цахим системийн хэрэгжилтийг 100 хувь ханган ажиллалаа. | 100 | 100 |
| 20. | | **Арга хэмжээ - 2.3.2**<br>Дүүргийн орон нутгийн хөгжлийн сан, дүүргийн төсвийн хөрөнгөөр | - | Үйл ажиллагаан ы хэрэгжилт, хувь | 100% | 100% | Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн тайлан мэдээг хуулийн хугацаанд shilendans.gov.mn сайт болон байгууллагын мэдээллийн самбарт | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажлын төлөвлөгөө болон улс, нийслэл, ОНХСан, дүүргийн хөрөнгө оруулалтын зарцуулалтыг shilendans.gov.mn сайтад байршуулж иргэдэд нээлттэй мэдээлэх. | | | | | байршуулж ажиллав.<br>Үүнд:<br>- 2024 оны Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөө,<br>- Шилэн дансны тухай бүр цэсэд 60, сар бүр цэсэд 32, бүтэн жил цэсэд 4, нийт 96 мэдээ байршуулав. Зарлан мэдээлэх журмын дагуу нээлттэй тендер шалгаруулалтын журмаар-10, шууд худалдан авалтаар-18, харьцуулалтын аргаар- 8, ерөнхий гэрээний аргаар-1 буюу нийт 37 бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг цахим системээр батлуулсан. 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн байдлаар 33 ажлын тендер шалгаруулалтыг зохион байгуулж дууссан бөгөөд төлөвлөгөөний биелэлт 91,8 хувьтай байна. Улс, нийслэл, дүүрэг ОНХС-ийн талаар 2024 онд төсөл хөтөлбөр арга хэмжээний төлөвлөгөөг 2, худалдан авах ажиллагааны хэрэгжилтийн тайланг 5, хөрөнгө оруулалтын явцын мэдээ 2, ОНХС-гийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр арга хэмжээний саналыг гар утасны аппилейкшн, цахимаар хэрхэн санал авах талаар мэдээллийг 4 удаа тус тус мэдээлсэн. | | |
| 2.4 | | **Зорилт - 2.4**<br>Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулан, төсөв, санхүүгийн сахилга хариуцлагыг сайжруулах<br>НЗДҮАХ 4.1.4<br>ХАХТ 4.1.4.1 | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 90 | 90 ба түүнээс дээш хувь | Орон нутгийн төсвийн 6, ТШЗ-ийн 5, ОНӨААТҮГ 3 байгууллага, дүүргийн хөрөнгө оруулалт, Орон нутгийн хөгжлийн сангийн 2022, 2023 оны жилийн эцсийн аудитын шалгалтаар баталгаажсан тайланг хүлээн авч нэгтгэсэн. ТЕЗ-ийн нэгтгэсэн санхүүгийн тайланг гарган Нийслэл дэх Төрийн аудитаар шалгуулан баталгаажуулж, дээд шатны байгууллагад | 90 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ДЗДҮАХ 3.1.5, 3.1.6, 3.1.7, 3.1.8 | | | | | хянуулан нэгтгэлд хамруулсан. Аудитын шалгалтаар “Зөрчилгүй” гэсэн санал дүгнэлтийг авч ажиллав. Дүүргийн улс, орон нутгийн төсвийн 18 байгууллагын 70 дансны орлого, зарлагын гүйлгээнд Төрийн сангийн төлбөр тооцоогоор дамжуулан хяналт тавин ажиллаж байна. МУЗГ-аас гаргасан төсвийг зөв зохистой ашиглах, хэмнэлтийн горимд шилжүүлэх тухай 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлж, тэвчиж болох урсгал зардлуудыг тодорхой хувиар бууруулж ажиллах талаар төсвийн байгууллага, ОНӨААТҮГ-т албан бичгээр тухай бүр зөвлөмж, чиглэл хүргүүлэн үйл ажиллагаанд нь хяналт, шаардлага тавин ажиллалаа. 2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн байдлаар төсвийн зарлага төлөвлөгөөгөөр 9,650,3 сая төгрөг байхаас гүйцэтгэлээр 8.299,7 сая төгрөгийг зарцуулж, 1,350,1 сая төгрөгийн хэмнэлттэй ажиллав. | | |
| 21. | **Арга хэмжээ - 2.4.1** Дүүргийн нутгийн захиргааны байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж, төсөв санхүүгийн сахилга батыг чанд мөрдүүлж хэвшүүлнэ. | - | Хэмнэгдсэн төсвийн мөнгөн дүн | 456.8 сая төгрөг | 750.0 сая төгрөг | Дүүргийн төсвийн байгууллагуудын батлагдсан төсвийн зориулалтын дагуу зарцуулагдаж байгаа эсэх өдөр тутмын төлбөр тооцоо хийхэд хяналт тавин ажиллаж байна. Төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлж төсвийг хэмнэж ажилласнаар 2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн байдлаар төсвийн зарлага төлөвлөгөөгөөр 9,650,3 сая төгрөг байхаас гүйцэтгэлээр 8.299,7 сая төгрөгийг зарцуулж, 1,350,1 сая төгрөгийн хэмнэлттэй ажиллав. | 90 | 100 |
| 2.5 | **Зорилт 2.5** Үйлдвэрлэл, инновац хөгжүүлнэ. /НХТЖҮЧ-4.3.3, НЗДҮАХ-3.2.2.1, НХТЖҮЧ-4.5.2, НЗДҮАХ-3.3.1.4, ДЗДҮАХ 3.2.1, | - | Арга хэмжээний хэрэгжилт, дундаж хувь | 90% | 100% | “Багахангайн үйлдвэрлэл технологийн парк”-ын үйл ажиллагааг эрчимжүүлэх хүрээнд паркт нэгжээр орсон "Сарьдаг хангайн оргил" ХХК төслийн 56 га талбайд 9 бүтээн байгуулалтын ажил эхлэн, гүйцэтгэл 71,1%-тай байна. | 90 | 90 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 3.2.2/ | | | | | | | |
| 22. | 2.5.1 | **Арга хэмжээ- 2.5.1** Эдийн засгийн хөгжлийг дэмжсэн, дэвшилтэт технологи бүхий үйлдвэрлэл, технологийн паркуудыг үе шаттайгаар байгуулна. | - | Арга хэмжээний хэрэгжилт, дундаж хувь | 90% | 100% | Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны өдрийн 36 дугаар тогтоолоор “Багахангайн үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-ын хуулийн хэлбэрийг өөрчлөн байгуулж, дүрмийг батлав. Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/346 дугаар захирамжаар паркийн дэд бүтэц, бүтээн байгуулалт цахилгаан хангамж 35 кВ-ын 2 хэлхээт цахилгаан дамжуулан шугам шинээр хийх ажилд 1,8 тэрбум төгрөг, шийдвэрлэгдэв. Паркийн “Мэдээлэл холбоо хангамж”-ийн зураг төслийн ажлыг Тенжин ХХК, “Үер усны байгууламж”-ийн зураг төслийг Гидродизайн инновац ХХК, “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ”-ний зураг төслийг Итгэл төгөл ХХК шалгарч гүйцэтгэж байна. Тус ажилд 62,5 сая төгрөг зарцуулагдаж байна. Паркт нэгжээр орсон "Сарьдаг хангайн оргил" ХХК төслийн 56 га талбайд бүтээн байгуулалтын ажил эхлүүлээд байна. Оффисын барилгын ажлын гүйцэтгэл 95%, ажилчдыг дотуур байр 80%, гал тогоо 80%, галд тэсвэртэй материалын цех 70%, нүүрсний агуулах 70% баяжуулах угаагч цех 45%, бэлэн бүтээгдэхүүний шахах цех-65%, 1 дүгээр зуухны барилга 85%, авто машины граж 50%, -тай байна. Төслийн талбайд ажиллах хүч нийт 147 хүн ажиллаж байгаагаас 134 Хятад, 13 Монгол улсын иргэн ажиллаж байна үүнээс 6 иргэн орон нутгаас ажиллаж байна. Мөн паркийн эзэмшил газар дээр Тен фрейт лайн ХХК “Тээвэр логистик нэгдсэн төв” барих төсөл, Эл Эс рейлвэй ХХК нь “Вагон хос дугуй засварлах төв” барих төслийг эхлүүлэхээр гэрээ байгуулан ажиллах гэж байна. | 90 | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.6 | | **Зорилт 2.6** Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр дэмжиж ажиллана. /НХТЖҮЧ-4.5.1, НЗДҮАХ-3.3.3.2, 3.3.3.3, НХТЖҮЧ-4.5.2, НЗДҮАХ-3.3.1, 3.3.1.4, 3.3.2.1, 3.3.2.6, ДЗДҮАХ 3.3.1, 3.3.2, 3.3.3, 3.3.4, 3.3.5/ | - | Арга хэмжээний хэрэгжилт, дундаж хувь | 90% | 100% | Нөөцийн махны өргөтгөсөн худалдааг 5 удаа зохион байгууллаа. И Эн Пи ХХК, “ХКҮ” ХХК-ны бэлтгэсэн хонь, ямааны нөөцийн мах бэлтгэсэн 1021ш гулууз 20,6 тн махыг дүүргийн 1,2-р хороонд худалдан борлуулсан. | 100 | 90 |
| 23. | 2.6.1 | **Арга хэмжээ 2.6.1** Мал амьтны гаралтай хүнсний болон хүнсний бус бүтээгдэхүүн, эмгэгт материалын дээжид хийх шинжилгээний тоог нэмэгдүүлж баталгаажуулалт олгоно. | 32.8 | Арга хэмжээний хэрэгжилт, дундаж хувь | 100% | 100% | Дүүрэгт Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар болон Нийслэлийн эрүүл мэндийн газрын эрүүл ахуйн халдварт хамгаалалтын Улсын байцаагч нар хүнсний дэлгүүр, хоол үйлдвэрлэл болон архи согууруулах ундаагаар үйлчилдэг тусгай зөвшөөрөл бүхий газруудад хяналт тавих зөвлөн туслах ажлын байрны дүгнэлт гаргахаар. 4 удаа ажиллав. Хяналт шалгалтаар 15 хуулийн этгээдийн ажлын байрны эрсдэлийг үнэлж, дүгнэн, хүнсний аюулгүй байдлын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бууруулах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах, таслан зогсоох тухай зөвлөмж өгсөн. УБЗАА-наас нөөцийн мах худалдан борлуулах аж ахуйн нэгж, байгууллагуудад сургалт зохион байгуулах хуваарийн дагуу Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтсийн Худалдаа үйлчилгээ, үйлдвэрлэл хариуцсан Ахлах мэргэжилтэн, нөөцийн мах худалдан борлуулах 1,2 дугаар хорооны “Сэтгэлийн гэгээ” ХХК, “Хангай булаг” ХХК-ны эрхлэгч нар 2024 оны 02 дугаар сарын 22-ний өдөр цахимаар хамрагдав. | 100 | 90 |
| 2.7 | | **Зорилт 2.7** **Аялал жуулчлал хөгжүүлнэ.** /НХТЖҮЧ- | 4.2 | Арга хэмжээний хэрэгжилт, | 100% | 100% | Дүүргийн ИТХ-ын 2023 А/11 дүгээр тогтоолоор хүүхдийн зуны зуслан байгуулах зориулалтын 3 га газрыг | 100 | 90 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 3.4.1, 3.4.3, НЗДҮАХ-3.5.1.1, 3.3.3.3, НХТЖҮЧ-3.4.4, НЗДҮАХ-3.5.3.1, ДЗДҮАХ 3.4.1/ | | дундаж хувь | | | Чингис хаан Үндэсний музейд олгохоор шийдвэрлэн зуны зуслан байгуулах ажлын хүрээнд Хот байгуулалт, хотын стандарт хяналтын газраас архитектур төлөвлөлтийн даалгаврыг авч хүүхдийн “Хөдөлмөр зуслан”-ийн зураг төсвийн ажил хийгдэж эхэлсэн ба 60 хувийн гүйцэтгэлтэй байна. | | |
| 24. | 2.7.1 | **Арга хэмжээ 2.7.1** Шинэ оны анхны нар угтах ёслол зохион байгуулна. | 4.2 | Арга хэмжээний хэрэгжилт, дундаж хувь | 100% | 100% | Дүүрэгт “Шинэ оны анхны нар харах” ёслолыг 2024.01.01-ний өдөр зохион байгуулж нийт 1000 гаруй тээврийн хэрэгсэл, 5000 орчим хүн хүрэлцэн ирснээс 100 орчим гадаадын жуулчид ирж оролцсон байна. Мөн хүрэлцэн ирсэн иргэдэд дүүргийн жижиг, дунд бизнес эрхлэгч иргэд халуун хоол цайгаар үйлчлэх, морь унуулах үйлчилгээ үзүүлэн 380,000 төгрөгийн борлуулалт хийв. Тус арга хэмжээнд дүүргийн засаг даргын нөөц хөрөнгөөс 2.259.800 төгрөг зарцуулав. | 100 | 100 |
| 2.8 | | **Зорилт 2.8 Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ нэмэгдүүлнэ.** /НХТЖҮЧ-4.3.1, НЗДҮАХ-3.4.2.2, НЗДҮАХ 3.5, ДЗДҮАХ 3.2.4, 3.2.5, 3.2.6, 3.2.7/ | - | Арга хэмжээний хэрэгжилт, дундаж хувь | 100% | 100% | ЖДҮДТөвийн байранд дүүргийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг 11 иргэдийг ажлын байраар хангах, борлуулалтыг дэмжиж ажиллаж байна. | 100 | 100 |
| 25. | 2.8.1 | **Арга хэмжээ 2.8.1** Олон улсын сайн туршлага, бизнесийн зөвлөх үйлчилгээ үзүүлж төрөлжсөн сургалт зохион байгуулна. | 1.0 | Арга хэмжээний хэрэгжилт, дундаж хувь | 100% | 100% | Монгол улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Жижиг, дунд үйлдвэрийн газар, Хөгжлийн шийдэл төрийн бус байгууллага, Улаанбаатар хотын Худалдааны танхим, Үндэсний ба олон улсын арилжааны арбитрын байгууллага, "Нийслэлийн Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих төв” НӨҮГ, Монголбанк, Бүгд Найрамдах Хятад Ард | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Улсын цахим худалдааны Zhubajie.com платформ, Налайх, Багануур дүүргийн ЗДТГ, дүүргийн Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төвтэй хамтран 10 удаагийн сургалтад тайлангийн хугацаанд давхардсан тоогоор нийтдээ 139 бичил бизнес эрхлэгч, 15 албан хаагч хамрагдав. | | |
| 26. | 2.8.2 | **Арга хэмжээ 2.8.2** Жижиг, дунд үйлдвэрлэл, бизнес эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүний борлуулалтыг олон улсын зах зээлд зуучлах арга хэмжээг 2-р нэмэгдүүлнэ /НХТЖҮЧ-3.4.4, НЗДҮАХ-3.5.4.1, ДЗДҮАХ 3.2.4, 3.2.5, 3.2.6 / | | 11.3 | Арга хэмжээний хэрэгжилт, дундаж хувь | 100% | 100% | ЖДҮД Төвийн байранд дүүрэгт үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх хүсэлтэй 15 иргэнийг ажлын байраар ханган, борлуулалтыг дэмжин ажиллаж байна.<br>Жижиг, дунд үйлдвэрлэл, бизнес эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүний борлуулалтыг нийслэл, дүүргээс зохион байгуулсан дараах арга хэмжээнүүдэд худалдан борлуулахаар гаргасан.<br>Үүнд:<br>• Нар харах арга хэмжээ<br>• Амар байна уу-2024<br>• “Цагаан сар” үзэсгэлэн худалдаа<br>• “Их хотын бүсгүйчүүд-2024”<br>• “Багахангай марафон -2024” Улсын аварга шалгаруулах гүйлтийн тэмцээ<br>• “Монгол гэр” үзэсгэлэн, арга хэмжээ<br>• Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр<br>• World Msme Folk-2024<br>• Хүрээ цам-Даншиг наадам<br>• Нүүдэлчин дэлхийн соёлын фестиваль<br>• Хичээлийн шинэ жилийн үзэсгэлэн худалдаа<br>• Алтан намар-2024<br>Намар-2024 зэрэг 13 удаагийн үзэсгэлэн худалдаа, арга хэмжээнд давхардсан тоогоор 33 бичил бизнес эрхлэгч иргэн, 6 ААНБ-ыг хамрагдаж, тайлангийн | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хугацаанд 43,6 сая төгрөгийн борлуулалт хийв. | | |
| **ГУРАВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО** | | | | | | | | | |
| **3.1. НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР, НИЙСЛЭЛИЙН ХӨГЖЛИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗААЛТУУДЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД (3 зорилт 12 арга хэмжээ)** | | | | | | | | | |
| 3.1. | | **Зорилт 3.1.** Гүйцэтгэлийн хяналтын тогтолцоо сайжирна /НЗДҮАХ 4.2.1, НЗДҮАХ 4.1.4, НЗДҮАХ 4.2.3, ХАХТ-4.2.3.3, ХАХТ-4.2.1.1/ | - | Үйл ажиллагаан ы хэрэгжилт, хувь | 70 | 90 ба түүнээс дээш хувь | Гүйцэтгэлийн хяналтын тогтолцоог сайжруулах хүрээнд 4 арга хэмжээг төлөвлөн, хэрэгжилт 95%-тай байна. Үүнд: Чанарын менежментийн тогтолцоог MNS ISO 9001-ийг нэвтрүүлэх ажлыг “Глобал куалити” аудитын ХХК-тай хамтран нэвтрүүлсэн.<br>Төрийн албан хаагчийн ур чадварыг хөгжүүлэх хүрээнд 14 удаагийн танхимын сургалтад 218 албан хаагч, иргэдийн хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх хүрээнд танхимын сургалт 24, цахим сургалт 3 удаа зохион байгуулан нийт 653 иргэд, албан хаагчийг хамруулав. Багахангай дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх, Хууль зүйн туслалцааны Налайх дүүрэг дэх салбар төвтэй хамтран иргэдэд хууль, эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл, үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлэх ажлыг 3 удаа зохион байгуулан 29 иргэдийг хамрууллаа.<br>Хуулийн төслийг танилцуулах хэлэлцүүлгийг танхимаар 1, цахимаар 2 удаа зохион байгуулан 20 санал, шинээр батлагдсан болон нэмэлт өөрчлөлт оруулах 11 хуулийн төсөлд нэмэлт оруулах 21, өөрчлөлт оруулах 24 санал нийт 45 саналыг нэгтгэн НЗДТГ-т хүргэн ажиллав. | 100 | 90 |
| 27. | 3.1.1 | **Арга хэмжээ- 3.1.1** Байгууллагын үйл ажиллагааг оновчтой зохион байгуулж, төрийн үйлчилгээний үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэн | - | Үйл ажиллагаан ы хэрэгжилт, хувь | 70 | 90 ба түүнээс дээш хувь | Төрийн байгууллагын үйл ажиллагааг оновчтой зохион байгуулж менежментийн сайн түвшинд хүрэх сайн засаглалыг бий болгох албан хаагчдын мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэх байгууллагын ажил үйлчилгээг чанаржуулан төрийн | 100 | 90 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | MNS ISO 9001 чанарын менежментийн тогтолцооны стандартыг нэвтрүүлнэ. | | | | | үйлчилгээний үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор Чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 стандартыг орон нутгийн захиргаанд хэрэглэх арга зүйн заавар ISO 18091: 2020 стандартыг нэвтрүүлэх зорилгоор Тамгын газрын даргын 2022 оны А/15 тушаалаар Бүтээмжийн болон Сургалтын багийг томилгоожуулсан. Чанарын менежментийн тогтолцооны баталгаажуулалт хөндлөнгийн аудит хийх ажлын гүйцэтгэгчээр “Глобал куалити” аудитын ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллалаа Чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлэх зорилгоор зөвлөх аудиторын зөвлөмжийн дагуу баримт бичиг, дүрэм журмыг боловсруулан батлуулж Гадаад дотоод орчны шинжилгээг хийж чанарын зорилгоо тодорхойлолоо. Төрийн байгууллагад менежментийн тогтолцоог амжилттай нэвтрүүлсэн туршлага судалж СХД-ийн ЗДТГ-ын хууль зүйн хэлтэстэй хамтран “Чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх арга зүй”-н сургалтыг хамтран зохион байгуулсан. “Глобал куалити” аудитын ХХК байгууллагын чанарын менежментийн тогтолцоонд баталгаажуулалтын хөндлөнгийн аудитыг хийж илэрсэн үл тохиролд хугацаатай зөвлөмж өгч ажиллав. Зөвлөмжийн дагуу албан хаагчдын чадамжийн түвшин тодорхойлох удирдамж 1, холбогдох чиг үүргийн 8 журам, 2 хөтөлбөр, 1 зураглалыг боловсруулан батлуулж 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр “Глобал куалити” аудитын ХХК-д хүргүүлээд байна. MNS ISO9001:2015 чанарын менежментийн тогтолцооны стандартыг нэвтрүүлсэн | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | баталгаажуулалтын гэрчилгээ авах шаардлагыг хангалаа. Тамгын газарт Чанарын менежментийн тогтолцоог нэвтэрснээр бодлого боловсруулах, төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах ажил тогтвортой сайжирч төрийн үйлчилгээний чанар бүтээмж эрс дээшилж байгууллагын тогтвортой хөгжилд дэмжлэг болж ажлын гүйцэтгэл сайжруулж тодорхой цэгцтэй хяналттай үнэлэх тогтолцоог бүрдүүлэх ач холбогдолтой. | | |
| 28. | 3.1.2 | **Арга хэмжээ-3.1.2.** Дүүргийн хөгжлийн бодлогыг шинээр боловсруулан батлуулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна. | - | Барим бичиг боловсруулах ажлын явц | - | 50 ба түүнээс дээш хувь | “Эс Ай Си Эй” судалгаа, зөвлөх үйлчилгээний ХХК-тай хамтран “БАГАХАНГАЙ 2040 ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР” бодлогын баримт бичгийг боловсруулан дүүргийн ИТХ-ын ээлжит XXV дугаар хуралдаанаар хэлэлцүүлэн, ИТХ-ын 2024 оны А/06 дугаар тогтоолоор батлуулав.Тус бодлогын баримт бичиг нь 2025 оноос хэрэгжинэ. | 100 | 100 |
| 29. | 3.1.3 | **Арга хэмжээ- 3.1.3** Төрийн албан хаагчдын ур чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн сургалтын агуулгыг сайжруулна. | - | Сургалтын тоо, хамрагдсан иргэдийн тоо | 29 900 иргэн, албан хаагч | 20 900-аас дээш иргэн, албан хаагч | Төрийн албаны хүний нөөцийг чадавхжуулах чиглэлээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн хөгжлийн төвөөс зохион байгуулагдсан сургалтад нийт 218 албан хаагч, яам, агентлаг, удирдлагын академиас зохион байгуулсан чуулга, хэлэлцүүлэг уулзалтад 40 албан хаагч нийт 258 албан хаагчийг хамруулан тухай бүр мэдлэг ур чадварыг дээшлүүлэн хэрэгжилтийг ханган ажиллав. | 100 | 100 |
| 30. | 3.1.4 | **Арга хэмжээ- 3.1.4** Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулах, аюулгүй ногоон бүсийг өргөжүүлнэ. | - | Зохион байгуулах төлөвлөгөөт сургалтын хувь<br>Ногоон бүс бүрдүүлсэн орчинг нэмэгдүүлсэ | 90<br><br>40 | 90<br><br>50 | “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль”, “Хүүхэд хамгааллын тухай хууль”, “Зөрчлийн тухай хууль”, “Залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” сургалтыг давхардсан тоогоор 36 байгууллагын 250 орчим иргэд, хүүхэд залуучуудад зохион байгууллаа. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх цахим мэдээллийг | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | н хувь | | | өөрийн сошиал хаягуудад нийт 792 удаа байрлуулж, 49060 иргэний хандалт авсан байна. Багахангай дүүргийн Засаг даргын 2024 оны 03-р сарын 06-ны өдрийн А/33 захирамжаар теле хяналтын камерын “Дэд төв” байгуулах ажлын хэсгийг байгуулсан.<br>Дүүргийн нутаг дэвсгэрт үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал “ArcGis” цэгийн мэдээлэлд үндэслэн Цагдаагийн ерөнхий газрын МШУТ-тэй хамтран Одоо ашиглаж байгаа 31 цэгт 41 ширхэг хяналтын камерын дэд бүтэц дээр шинээр нэмж 91 ширхэг чиглэлийн, 33 хөдөлгөөнт хяналтын камер байрлуулж, нийт 64 цэгт 164 ширхэг хяналтын камер байрлуулах тооцооллыг гаргасан. Теле хяналтын камерын “Дэд төв”-ийн байрыг 2-р хороо, хорооны байрны 2 давхарт байрлуулахаар засварын ажлыг “Бодь электроникс” ХХК гүйцэтгэн бүрэн дууссан, тоног төхөөрөмж байрлуулах ажлыг гүйцэтгэн энэ оны 12-р сард ашиглалтад оруулахаар төлөвлөсөн.<br>“Green zone” хөтөлбөрийн хүрээнд аж ахуйн нэгж, байгууллагуудын гадна орчинд камерт үзлэг шалгалт хийж стандарт шаардлага хангахгүй 24 теле хяналтын камер шинээр суурилуулж нийт 150 цэгийн 158 теле хяналтын камерыг http://www.camera.police.gov цахим санд шивж баталгаажуулан “Дэд төв холбоход бэлэн болгосон. Дүүргийн хүн ам, нутаг дэвсгэр нягтаршилд үндэслэн аж ахуйн нэгж, байгууллагын гадна орчны 133 камерыг шивж оруулахаар тооцоолсон гүйцэтгэл 118 хувьтай буюу 18 хувиар давуулан биелүүлсэн. | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.2 | | **Зорилт 3.2** Хүн төвтэй, олон нийтийн оролцоотой, иргэдэд хүрсэн төрийн үйлчилгээг хэвшүүлнэ./ДЗДҮАХ-4.1, НХТЖҮЧ-5.2, НХТЖҮЧ-5.3.2, / | - | Арга хэмжээний хэрэгжилт, дундаж хувь | 90 | 91 | Дүүргийн веб сайт болон "Багахангайн мэдээ" фейсбүүк, хороодын чат группээр дамжуулан иргэдэд мэдээ мэдээллийг тухай бүр өгч хэвшээд байна. Аж ахуйн нэгж, байгууллагууд өөрсдийн цахим хуудас болон "Нээлттэй хаалганы өдөрлөг" арга хэмжээний үеэр ажлаа иргэдэд сурталчлан ажиллалаа. Дүүргийн Засаг даргын 2024 оны А/81, 175 дугаар захирамжаар батлагдсан мэргэжлийн байгууллагын ажлын хэсэг "Явуулын нэг цэгийн үйлчилгээ"-г үзүүлж давхардсан тоогоор 28 төрлийн үйлчилгээг 59 өрхийн 81 иргэнд үзүүлж, 33 төрлийн 633 гарын авлага тараах материалыг иргэдэд олгов. "Хурдан" цэгийн үйл ажиллагаа хороодод хэрэгжиж эхэлснээр нийт 76 иргэнд үйлчилгээ үзүүлсэн. Мөн 2024.10.28-ны өдөр "Нээлттэй хаалганы өдөр" арга хэмжээний үеэр "Хурдан" цэгийн үйл ажиллагааг ард иргэдэд сурталчлан нийт 12 иргэнд үйлчилгээ үзүүлж ажиллалаа. | 90 | 70 |
| 31. | 3.2.1 | **Арга хэмжээ- 3.2.1** Гадаад харилцаат хотуудтай харилцан ашигтай худалдаа, эдийн засаг болон олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэх арга хэмжээг зохион байгуулна. | - | Туршлага судалсан албан хаагчийн тоо | 10 байгууллагын 22 албан хаагч | 2-оос доошгүй албан хаагч | Дүүргийн зүгээс БНСУ-ын Ванжу-гун, Жооллабук-до газар тариалан, загас агнуурын тосгонд улирлын чанартай ажилчин нийлүүлэх ажлын хүрээнд 3 иргэн нь 6 сарын хугацаатай улирлын чанартай ажлыг БНСУ-д хийсэн. Дүүргээс 2024 оныг "Бүтээмж-Хамтын ажиллагааг дээшлүүлэх зорилтот жил" болгон зарласантай холбогдуулан 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр Багахангай дүүрэг, Бүгд Найрамдах Солонгос Улсын Сөүл хотын "KK MEDIA" ХХК-тай соёл урлаг, аялал жуулчлалын чиглэлээр хамтын ажиллагаа тогтоов. | 70 | 70 |
| 32. | 3.2.2 | **Арга хэмжээ- 3.2.2** Дотоод удирдлагын /UB ERP/ программын үйлчилгээний | - | /UB ERP/ программын ашиглалтын хувь | 90 | 90 ба түүнээс дээш хувь | Дотоод удирдлагын /UB ERP/ системийн Цаг бүртгэл, ажлын хэсэг, хурал уулзалт үүрэг даалгаврын, хяналт шинжилгээ үнэлгээ, өргөдөл гомдол дэд системийн | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | үзүүлэлтийг сайжруулах ажлыг зохион байгуулна. | | | | | ашиглалтыг сайжруулан ажиллаж байна. Тайлангийн хугацаанд ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ дэд системд нийт 132 үүрэг даалгаврын хэрэгжилтийг хянаж, өргөдөл, гомдол дэд цэсээр 283 өргөдлийг бүртгэн, шийдвэрлэлт 97,8%, цаг бүртгэл дэд цэсээр албан хаагчдын бүртгэлийг тухай бүр хийж 663 хүсэлтийг тус тус шийдвэрлэж ажиллалаа. Архивын баримтад цахим хувь үйлдэх захирамжлалын баримтыг цахим хэлбэрт оруулах ажлыг дүүрэгт зохион байгуулан ажиллаж байна. Архивын нэгдсэн “AMS” программд харьяа 26 байгууллагын 54 хадгаламжийн нэгжийн 2017 баримтын 4390 хуудас хадгаламжийн нэгжид өгөгдөл шивж оруулсныг батлан шалгаж дуусгаад байна. | | |
| 33. | 3.2.3 | **Арга хэмжээ- 3.2.3**<br>Иргэдийг мэдээ, мэдээллээр ханган, иргэдэд ажлаа тогтмол тайлагнана. | Орон нутгийн төсөв 1.2 | Шийдвэрлэлтийн дундаж хоног<br><br>Арга хэмжээнд оролцогчдын тоо | 6 хоног<br><br>1789 | 6 хоног<br><br>930 ба түүнээс дээш | Дүүргийн веб сайт болон “Багахангайн мэдээ” фейсбүүк, хороодын чат группээр дамжуулан иргэдэд мэдээ мэдээллийг тогтмол өгч хэвшээд байна. Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй нутгийн захиргааны байгууллага болон үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг иргэдэд сурталчлах "Нээлттэй хаалганы өдөрлөг"-ийг 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдөр, Хуулийн салбарын “Эрүү шүүлтээс ангид байх эрх” нээлттэй хаалганы өдөрлөг, арга хэмжээг 2024 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр зохион байгууллаа. Арга хэмжээнд дүүргийн аж ахуйн нэгж 17 байгууллага, хууль шүүхийн 7 байгууллага оролцон үйл ажиллагаагаа сурталчлан “Эрүү шүүлтийн хор аюул, түүнээс ангид байх эрхийн талаарх ойлголт” сэдвээр сургалт, хууль, эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл, үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлэн ажиллаа. Арга хэмжээнд 56 иргэн хамрагдсан байна. | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Хүний эрхийн олон улсын өдрийг угтаж Хүний эрхийн комисстой хамтран "Хүний эрхийн төлөө хамтдаа" нээлттэй өдрийг 2024 оны 12 дугаар сарын 06-ний өдөр зохион байгуулж, сургалт хэлэлцүүлгийн арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Тайлангийн хугацаанд 4 төрлийн мэдээллийн сувгаар дамжуулан 138 төрлийн мэдээ мэдээллийг 1854 иргэнд өгч ажиллалаа. | | |
| 34. | 3.2.4 | **Арга хэмжээ- 3.2.4** Дүүргийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг тогтмолжуулах, чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ. | Орон нутгийн төсөв 0.3 | Арга хэмжээний хэрэгжилт, дундаж хувь | 90 | 90 ба түүнээс дээш хувь | Дүүргийн архив, албан хэрэг хөтлөлтийн төлөвлөгөөг 10 бүлэг 25 нь заалттайгаар боловсруулан үйл ажиллагааны хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Дүүргийн аж ахуйн нэгж, байгууллагуудад архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд архив, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр давхардсан тоогоор 46 байгууллагын 102 ажилтан, албан хаагчдад 4 удаагийн сургалт зохион байгуулаад байна. 2024 оны жилийн эцсийн байдлаар 215 баримтыг түр хугацаагаар ашиглуулж, 87 лавлагаа хуулбар хувь олгож, захирамжлалын баримт бичиг болох Засаг даргын захирамж (А)-194, захирамж (Б)-31, Тамгын газрын даргын тушаал (А)-53, тушаал (Б)-87, нийт 365, 854 албан бичгийг стандартын дагуу хэвлэмэл хуудсанд хэвлэн ажиллалаа. Цахим архив үүсгэх ажлын хүрээнд 26 байгууллагын 54 хадгаламжийн нэгжийн 2017 баримтын 4390 хуудас баримтад батлан шалгалтын ажлыг хийж ажиллаж байна. | 100 | 100 |
| 35. | 3.2.5 | **Арга хэмжээ- 3.2.5** Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл нийгмийн баталгааг дээшлүүлэн, ёс зүйн | Орон нутгийн төсөв 1.0 | Арга хэмжээний хэрэгжилт, дундаж хувь | 90 | 90 ба түүнээс дээш хувь | Төрийн албаны тухай хууль, Байгууллагын хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд заасны дагуу 10 албан хаагчдад мөнгөн урамшуулал, Алдарт эхийн одон авсан 1 албан хаагч, Эрүүл мэндийн шалтгаанаар | 90 | 90 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | зөрчлөөс урьдчилан сэргийлэх нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулна. | | | | | дүүрэгт, хотод хэвтэн эмчлүүлсэн 5 албан хаагчид мөнгөн урамшуулал олгон, байгууллагын зардлаар 2 албан хаагчийг 544,000 төгрөгөөр сургалтад хамруулав. Байгууллагын зардлаар сургалтад хамрагдсан 1 албан хаагчид 5 хоногийн цалинтай чөлөөг үндэслэн шинээр төрсөн хүүхэд асрахад зориулах 10 хоногийн цалинтай чөлөө 2 албан хаагчдад олгов. ЗГ-2024 оны 128 дугаар тогтоолын хүрээнд цалингийн өөрчлөлтийг нийт 40 албан хаагчдад хийж ЗГ-ын 2024 оны 83 дугаар тогтоолыг үндэслэн Төрийн захиргааны албан тушаалд тасралтгүй таван жил болон түүнээс дээш хугацаанд ажилласан албан хаагчдад 6 сарын үндсэн цалинтай тэмцэх хэмжээний мөнгөн мөнгөн урамшуулал нийт 13 албан хаагчдад олголоо. Нийслэл дэх төрийн аудитаар “Өөрчлөлтгүй” дүгнэлт авсан 1 албан хаагчдад 2 сарын үндсэн цалингийн урамшуулал олгов. Тэтгэвэр тогтоолгох насанд хүрч тэтгэврээ тогтоолгох хүсэлт гаргасан 2 албан хаагчдад 63.0 сая төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж олгосон.Албан хаагчдад өдрийн хоолны зардлыг шинэчлэн 34,000 төгрөгөөр тогтоов. Мөн нууцын нэмэгдлийг 1 албан хаагч,албан тушаалын зэрэглэлийн цэргийн цол олгох 2 албан хаагч, унааны зардлыг 3 албан хаагч, түр орлон гүйцэтгүүлэн үндсэн цалингийн 40 хувийн нэмэгдлийг 9 албан хаагч нийт 14 албан хаагчдад олгон ажилласан. Засаг даргын 2019 оны А/204 дүгээр захирамжийг үндэслэн 0-18 хүртэлх насны хүүхэдтэй албан хаагчдад хүүхдийн төрсөн өдрөөр 8 албан хаагчдад цалинтай чөлөө олгов. Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсэгт заасны дагуу 2 | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | албан хаагчийг шилжүүлэн ажилласан байна. Давхардсан тоогоор 54 албан хаагчийг ажиллах нөхцөл, нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн байна. Жилийн эцсийн байдлаар төлөвлөгөөний биелэлт 93.3%-тай байна. | | |
| 3.3 | | **Зорилт 3.3** Иргэн цэргийн харилцааг бэхжүүлэн, сургалтын үйл ажиллагааг зохион байгуулна. | - | Арга хэмжээний хэрэгжилт, дундаж хувь | 90 | 90 ба түүнээс дээш хувь | Дүүргийн Засаг даргын 2024 оны А/29 дүгээр захирамжаар Монгол улсад орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 103 жилийн ой, “Монгол цэргийн өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх төлөвлөгөөг баталж, тэмцээн уралдаан, ёслолын арга хэмжээг зохион байгууллаа. Монгол улсад орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 103 жилийн ой, “Монгол цэргийн өдөр” “Халх голын ялалтын 85 жилийн ойг” тохиолдуулан бүсийн дуу дуулаачдын уралдаан, Багахангай дүүрэг, Баян сумын Төрийн цэргийн болон хууль сахиулах анги байгууллагуудын Марш тактикийн тусгай бэлтгэлийн аварга тасаг шалгаруулах тэмцээн, дүүргийн нутаг дэвсгэрт байрлах "Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагууд” –ын албан хаагчдын дунд хийн буудлагын тэмцээн зэрэг арга хэмжээг төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан. | 100 | 100 |
| 36. | | Батлан хамгаалах хууль тогтоомжийг сурталчлах арга хэлбэрүүдийг өргөжүүлэн иргэдэд хууль эрх зүйн мэдээ мэдээлэл, Цэргийн алба хаах хэлбэрүүдийг сурталчлах ажлыг тогтмолжуулж иргэн цэргийн харилцааг бэхүүлнэ. | 15.8 | Цэргийн штабаас хэрэгжүүлэх ажил үйлчилгээ, төрөл | - | төрөл 5, ажил үйлчилгээ 30 | Тайлангийн хугацаанд Батлан хамгаалахын сайд нийслэлийн Засаг даргатай 2024 онд хамтран ажиллах гэрээний 3 дугаар хавсралтын 3.1.3 дахь заалтад тусгагдсан ажил үүргийг гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган батлуулан ажиллаж байна. Цэргийн штабын дайчилгааны болон нууц материалын хадгалалт хамгаалалт, бичиг баримтын хөтлөлтийг заавар дүрмийн дагуу хэрэгжилтийг ханган Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | штаб, НЗДТГ-ын Цэргийн штабаас ирүүлсэн зөвлөмж, үүрэг, чиглэлийг өөрийн хариуцсан ажилдаа мөрдлөг болгон ажиллаж байна. Батлан хамгаалах салбарын бодлого, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх, хяналт тавих, бодлого үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, мэдээллээр хангах ажлыг үе шаттай зохион байгуулан ажиллаж байна. | | |
| 37. | | Өсвөр үеийн хүүхэд багачуудад эх оронч үзэл хүмүүжил төлөвшүүлэх, Цэргийн насны залуучуудын эрүүл мэндийг сайжруулах ажлыг дүүрэг орон нутгийн хэмжээнд холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулна. | 3.0 | Зохион байгуулсан ажил үйлчилгээний төрөл | - | 16 | Өсвөр үеийн хүүхэд багачуудад эх оронч үзэл хүмүүжил төлөвшүүлэх хүрээнд дараах арга хэмжээнүүдийг зохион байгуулсан. Үүнд: Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 103 жилийн ойн арга хэмжээний хүрээнд “Миний мэдэх Халх голын дайн” эссэ бичлэгийн уралдаан, “Халх голын ялалт” гар зургийн уралдааныг ЕБС-ийн хүүхдүүдийн дунд зохион байгуулсан. Нийслэлийн аварга шалгаруулах цэрэг спортын “Дөл” тэмцээнд Хангай ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын “Жигүүр” баг оролцсон.<br>НЗДТГ-ын Цэргийн штабаас санаачлага, дүүргийн ЗДТГ-ын удирдлагын дэмжлэгээр “Эх оронч үзэл үндэсний бахархал” сэдэвт сургалтыг зохион байгуулан “Хангай” цогцолбор сургуулийн ахлах ангийн сурагчдыг хамруулав. Батлан хамгаалах бодлого, Зэвсэгт хүчний үйл ажиллагаа, хууль тогтоомжийг сурталчлах, хүүхэд залуучуудад эх оронч үзэл санааг төлөвшүүлж энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн дүүргийн албан хаагчдаа алдаршуулах, хүүхэд залуусын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд чиглэн “Хийн буудлага”-ын тэмцээнийг зохион байгуулав. Тулгар төрийн 2233, Их Монгол улс байгуулагдсаны 818, Үндэсний | 90 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 113, Ардын хувьсгалын 103 жилийн ой, нийслэлийн Багахангай дүүрэг үүсэн байгуулагдсаны 35 жилийн ойг тохиолдуулан Төрийн далбаа, Нийслэлийн туг, Багахангай дүүргийн тугийг мандуулах ёслолын ажиллагаа 2024 оны 07 дугаар сарын 09-ны өдөр дүүргийн төв талбай дээр зохион байгуулсан. Дүүргийн Засаг даргын 2024 оны А/140 дүгээр захирамжаар Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын Улсын дайчилгаа, орон нутгийн хамгаалалтын хэлтэс байгуулагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллага, Монгол цэргийн холбоо, Орон нутгийн хамгаалалтын удирдах бүрэлдэхүүний дунд дүүргийн Спорт хороотой хамтран 2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр ”Буудлагын тэмцээн” зохион байгуулаа. Тэмцээнд нийт 13 багын 26 тамирчин өрсөлдлөө.<br>Тэмцээний тэргүүн байранд Орон нутгийн хамгаалалтын удирдах бүрэлдэхүүний багийн тамирчин Д.Хүрэлбаатар алтан медаль, мөнгөн шагнал, дэд байранд ШШГЕГ-ын харьяа хаалттай, нээлттэй Хорих 415 дугаар ангийн багийн тамирчин Б.Энхбат мөнгөн медаль, мөнгөн шагнал, гутгаар байранд ШШГЕГ-ын харъяа СМДОӨ албадан эмчлэх, хөдөлмөр хийлгэх газрын тамирчин Ч.Энхбаяр хүрэл медаль, мөнгөн шагналаар шагнагдсан.<br>- Дүүргийн Ерөнхий боловсролын Хангай сургуулийн 15 сурагч, 1 багшийг Батлан хамгаалах яамнаас зохион байгуулсан “Эх оронч суралцагч” сэдэвт арга хэмжээнд батлагдсан хөтөлбөр удирдамжийн | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | дагуу Сэлэнгэ аймгийн түүхэн дурсгалт газруудаар 2024 оны 9 дүгээр сарын 20, 21-ний өдрүүдэд аялуулсан<br>- Цэргийн насны залуучуудын өвчлөлийн ангилал дарааллыг тогтоож урт болон богино хугацаанд эмчлэгдэх өвчлөлийн зэрэглэлийн дагуу дүүргийн болон Улаанбаатар хотын 1, 2 дугаар шатлалын эмнэлгийн нарийн мэргэжлийн эмчийн хяналтад шилжүүлэн эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлж байна | | |
| 38. | | Дүүргийн орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөний дагуу томилгоот нэгжийн бүрэлдэхүүн, салаадын үүрэг гүйцэтгэх үеийн сургалт дадлагыг зохион байгуулах, шаардагдах техник хэрэгсэл, хүн амын зайлшгүй хэрэгцээний гол нэрийн бараа материалын нөөцийг үе шаттайгаар бүрдүүлэх замаар төлөвлөгөөний хэрэгжилтийг хангана. | 15.0 | Зохион байгуулсан сургалт дадлага | - | 2 | Зэвсэгт хүчний 284 дүгээр ангитай хүн, техникийн дайчилгааны тодотголыг дүүргийн Засаг даргын захирамжийн хугацаанд зохион байгуулж актыг НЗДТГ-ын Цэргийн штабт хүргүүлсэн. Мөн Улсын болон Цэргийн дайчилгааны төлөвлөлтийн баримт бичгүүдэд тодотгол хийж хэрэгжүүлэх үйл ажиллагаанд дүүргийн удирдлагад мэргэшил арга зүйн дэмжлэг үзүүлэн актыг хүргүүлсэн. Дүүргийн Засаг даргын 2024 оны н/04 дүгээр захирамжаар Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөний дагуу томилгоот нэгжийн бүрэлдэхүүн, салаадын үүрэг гүйцэтгэх үеийн сургалт дадлагыг зохион байгуулсан. Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2020 оны 600/02, 2021 оны Стратегийн удирдамж 600/01-ийн дагуу “Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын бэлэн байдлын зэргүүдэд шилжүүлэх төлөвлөгөө”, “Зэвсэгт хүчний анги, салбарыг дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүн, техникээр нөхөн хангах төлөвлөгөө”, “Орон нутгийн цэргийг байгуулах, бэлтгэлийг хангах төлөвлөгөө”, “Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг ханган, улирал бүр | 90 | 70 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | тодотгож, ажиллаж байна. Цугларах байрын томилгоот албан тушаалтны сургалтыг 2024 оны 10 дугаар сарын 17-ны өдөр ерөнхий боловсролын Хангай сургууль дээр зохион байгуулж, сургалтаар “Цугларах байр”-ын үүрэг зориулалт тасгийн үйл ажиллагааг томилгоот бие бүрэлдэхүүний үүргийг танилцуулж сургалт, дадлага хийж үүрэг гүйцэтгэх чадамж харилцан ажиллагааг нэмэгдүүлсэн. Зэвсэгт хүчний 014 дүгээр анги дээр 2024 оны 12 дугаар сарын 06-08-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Багахангай, Налайх, Багануур дүүргийн хорооны Засаг дарга нарын цэргийн бэлтгэл сургалтад Засаг дарга нарыг оролцуулж мэдээ мэдээлэл өгч мэдлэг чадвар олгосон. | | |
| **ДӨРӨВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО (1 зорилт 9 арга хэмжээ)** | | | | | | | | | |
| 4.1 | | **Зорилт 4.1 Агаар орчны бохирдолоос урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулна.** /АХ-2.5.9, 2.5.10, НЗДҮАХ-6.2.1, 6.2.3, НХТЖҮЧ-5.2.1, 5.2.7, ДЗДҮАХ 5.1.3, 5.2.4/ | 5.3 | Арга хэмжээний хэрэгжилт, дундаж хувь | 100% | 100% | Орчны бохирдлын эх үүсвэр, хаягдлын тооллогын мэдээллийн сан”-ийн системд ердийн галлагаатай 3-15 кВт болон 15-100 кВт хүчин чадал бүхий зуухтай өрхийн судалгаа, Усан халаалтын 101-4200 кВт хүртэл хүчин чадалтай зуухны тооллогыг бүртгэж ажиллав. | 100 | 100 |
| 39. | 4.1.2 | **Арга хэмжээ- 4.1.2** Агаар орчны бохирдлыг бууруулахад, иргэд зөв дадал, зохистой хэрэглээг сайжруулж, олон нийтийн оролцоог нэмэгдүүлнэ /АХ-2.5.9, 2.5.10, НЗДҮАХ-6.2.1, 6.2.3, НХТЖҮЧ-5.2.1, 5.2.7, ДЗДҮАХ 5.1.3, 5.2.4/ | 5.3 | Арга хэмжээний хэрэгжилт, дундаж хувь | 100% | 100% | Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны А/479 тушаалын хэрэгжилтийг ханган Агаарын бохирдлын эх үүсвэрийн бүртгэл, тооллогын ажлыг удирдамжийн дагуу зохион байгуулсан. Дүүргийн 1, 2 дугаар хорооны нутаг дэвсгэрийн хэмжээнд ердийн галлагаатай 3-15 кВт болон 15-100 кВт хүчин чадал бүхий зуухтай өрхийн судалгаа маягтын дагуу, Усан халаалтын 101-4200 кВт хүртэл хүчин чадалтай зуухны тооллого бүртгэлийг “Орчны бохирдлын эх үүсвэр, | 100 | 70 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хаягдлын тооллогын мэдээллийн сан”-ийн системд тус тус бүртгэж ажиллав. Тус ажлыг хороодын 2 зохион байгуулагч нараар ахлуулан, 4 хэсгийн ахлагч хамтран зохион байгуулж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав. 2024 оны 11 дүгээр сарын 29 нд Илч–Орд ОНӨААТҮГ-ын халаалтын зууханд утаа, тортог шүүгч Циклон нийлүүлэх ажлын тендер дүүргийн төсвийн хөрөнгөөр зарласан бөгөөд тус ажилд 3 компани материал ирүүлэн үнэлгээний шатандаа байна. Тус ажилд 135,0 сая төгрөг зарцуулахаар төсөвлөв. | | |
| 40. | 4.1.3 | **Арга хэмжээ- 4.1.3** Байгаль орчин тогтвортой байдлыг хадгална /АХ-6.1.4, НЗДҮАХ-6.1.1,6.1.2, НХТЖҮЧ-5.3.1, 5.3.3, ДЗДҮАХ- 5.1.1, 5.1.2, 5.1.3, 5.2.1/ | 91.3 | Арга хэмжээний хэрэгжилт, дундаж хувь | 100% | 100% | Хавар намрын “Бүх нийтээр мод тарих” арга хэмжээнд 18 аж ахуйн нэгж байгууллага, 346 ажилтан, албан хаагч, иргэд оролцож нийт 6 төрлийн 7220 ш мод бут, сөөг тарьж тус ажилд нийт 15.8 сая төгрөг зарцуулав. Намрын мод тариалалтаар мод бут тарих хүсэлт ирүүлсэн аж ахуйн нэгж, иргэдэд мод бут олгож, суулгах заавар зөвлөгөө өгч хамтран ажиллав. Тайлангийн хугацаанд нийт 7220 ширхэг мод бутыг намрын цэнэг усалгаа хийсэн. 1-р хорооны 59 иргэн, 2-р хорооны 50 иргэнд 151ш үхрийн нүд, 78ш гүйлсний суулгац өгсөн ба 2024 онд нийт 109 өрхөд гоёлын, жимсний, навчит зэрэг 1596 ширхэг мод олгов. | 90 | 100 |
| 41. | 4.1.4 | **Арга хэмжээ- 4.1.4** Хот суурин газрыг дахин хөгжүүлэх, шинэ суурьшлын бүсийг хөгжүүлэх төслийг гүйцэтгэлийг 15 хувиар нэмэгдүүлнэ /АХ-9.3.4, НХТЖҮЧ-9.7.1, НЗДҮАХ-6.1.8/ | 11.0 | Арга хэмжээний хэрэгжилт, дундаж хувь | 100% | 100% | Хот суурийн газрын дахин хөгжүүлэх орон сууцжуулах ажлын хүрээнд 1,2 дугаар хорооны 416 айлын орон сууцыг барихаар төлөвлөгөөнд тусган ажиллаж байна. Монгол Улсын Их Хурлын 2024 оны 723 дугаар тогтоолоор Нийслэлийн Багахангай дүүргийн чиг үүргийг Багахангай дагуул хотод, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын чиг үүргийг тус хотын Зөвлөлд, дүүргийн Засаг даргын чиг үүргийг тус хотын Захирагчид хотын эдэлбэр газрын | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хэмжээнд хэрэгжүүлэхээр заасан. | | |
| 42. | 4.1.6 | **Арга хэмжээ- 4.1.6** Төвлөрсөн ус хангамжийн шугам сүлжээнд холбогдох нөхцөлийг 3 хувиар нэмэдүүлнэ /АХ-9.2.15, 9.3.35, МУХТЖҮЧ-9.3.3, МУЗГҮАХ-3.7.11, НХТЖҮЧ-9.15.3, 9.16.1, 9.16.2, 9.16.3, НЗДУБХЗҮАХ-6.3.24, 6.3.23, 6.3.24, 6.3.25, 6.3.26, ДЗДҮАХ 6.4.1, 6.4.4/ | 48.0 | Арга хэмжээний хэрэгжилт, дундаж хувь | 100% | 100% | Дүүргийн УСАТ, Дэээрэт олон Улсын байгуулагатай хамтран 1,2 дугаар хорооны зөөврийн ус түгээх 4 байранд ухаалаг төхөөрөмж суурилуулж, 24 цагаар тасралтгүй ундны усаар ханган ажиллаж байна. Тус ажилд Ус суваг удирдах газраас 44,0 сая төгрөг зарцуулав | 100 | 100 |
| 43. | 4.1.7 | **Арга хэмжээ- 4.1.7** Төв суурин газрын эрчим хүчинд холбогдоогүй хэрэглэгчдийг 12.5 хувиар бууруулна /АХ-4.2, НХТЖҮЧ-9.11.1, НЗДУБХЗҮАХ- 6.3.30, ДЗДҮАХ 6.5.1, 6.5.2, 6.5.3, 6.4.4, 6.6.5/ | 848.0 | Арга хэмжээний хэрэгжилт, дундаж хувь | 100% | 100% | Дүүргийн 1,2 дугаар хорооны нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд 930ш гэрэлтүүлэг ажиллаж байна. Нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн гэрэлтүүлэг өвөл зуны улираас хамаарч сар бүр батлагдсан хуваарийн дагуу зун улиралд орой 19 цагаас 23цаг, өвөл 17:30 цагаас шөнийн 00 цаг, 1 дүгээр хорооны төвийн гэрэлтүүлэг зун 19 цагаас шөнийн 02 цаг, өвөл 17:30 шөнийн 02 цаг, авто постын замын гэрэлтүүлэг зун 19 цагаас шөнийн 03 цаг, өвөл 17:30 цагаас шөнийн 03:00 цаг хүртэл ажиллаж гэрэлтүүлгийн асалт 99%-тай байна. Гэрэлтүүлгийн засвар үйлчилгээнд 10.4 сая зарцуулсан. Мөн 1-р хорооны Үнэгтэй гэр хорооллын авто зам, сургуулийн авто зам, 2-р хороо спорт заалнаас бор үзүүр, 1, 2р хороог холбосон авто замын дагуу 98ш нэмэлт гэрэлтүүлэг угсарч ажиллагаанд оруулсан. 1-р хорооны Үнэгтэй гэр хорооллын эрчим хүчний өргөтгөлийн ажил, 2 дугаар хорооны Цайдам, Бор-Үзүүр, Замчны гэр хорооллын эрчим хүчний шугам сүлжээг нэмэгдүүлэх ажлыг 1,2 тэрбум төгрөгийн | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | өртөгтэйгөөр Улсын төсвийн хөрөнгөөр Эрчим хайрхан ХХК гүйцэтгэж дуусган ашиглалтад 8 сард Улсын комисст хүлээлгэн өгөв. | | |
| 44. | 4.1.8 | **Арга хэмжээ- 4.1.8** Гүйцэтгэлийн хяналтын тогтолцоо сайжирна /НЗДҮАХ 4.2.1, НЗДҮАХ 4.1.4, НЗДҮАХ 4.2.3, ХАХТ-4.2.3.3, ХАХТ-4.2.1.1 НХТЖҮЧ 5.1.2 ДЗДҮАХ 3.2.3/ | - | Үйл ажиллагаан ы хэрэгжилт, хувь | 100 | 100 | Онлайн бизнес төвд худалдаа үйлчилгээ 3, Тусгай зөвшөөрөл хүссэн-11, нийт 14-өөс 100% шийдвэрлэсэн. Согтууруулах ундаа худалдаалах, үйлчлэх 11 хуулийн этгээд Онлайн бизнес төвд Нийслэлийн ХХААГ-т хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн ажлын байрны дүгнэлт гаргуулахаар хүсэлт 11 илгээж дүгнэлт гаргуулсан. Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/219 дүгээр захирамжаар Согтууруулах ундаа худалдах, үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох эрх дүүргийн Засаг даргад шилжиж ирсэнтэй холбогдуулан дүүргийн Засаг даргын 2024 оны өдрийн А/52 дугаар захирамжаар Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой асуудлаар дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг 11 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулагдав. Худалдаа үйлчилгээг зохицуулах салбар зөвлөл 6 удаа хуралдаж, тусгай зөвшөөрөл шинээр 11 хуулийн этгээдэд дүүргийн Засаг даргын 2024 оны А/100, А/121, А/125, А/139, А/155, А/167 дугаар захирамжаар тус тус Тусгай зөвшөөрөл 5 жилийн хугацаатайгаар (13 цэгт) олгов. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас дүүргүүдэд шилжсэн худалдаа, үйлчилгээний чиглэлийн үйл ажиллагаа, тусгай зөвшөөрөл олголт болон салбарын хууль тогтоомж, журмын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх ажлыг Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн тушаалаар батлагдсан удирдамж, чиглэлийн дагуу | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | шалгуулав. | | |
| 45. | 4.1.9 | **Арга хэмжээ- 4.1.9** Орон сууц, нийтийн аж ахуйн хүчин чадлыг нэмэгдүүлж, амьдрах орчны аюулгүй байдлыг хангана / НХТЖҮЧ 7.3.2, 9.11.1, НЗДҮАХ 6.3.30, ДЗДҮАХ 6.6.3/ | 80.0 | Арга хэмжээний хэрэгжилт, дундаж хувь | 100 | 100 | Монгол чех метал ХХК нь дүүргийн 1 дүгээр хорооны урд талд 4 блок 12 давхар нийт 320 айлын орон сууц барихаар эрчмийн техникийн нөхцөл болон газар эзэмшигчийн нэр солих ажил хийгдэж байна. НОСК-ийн 1,2 тэрбум төгрөгийн хөрөнгөөр дүүргийн 2 дугаар хороонд 8 айлын орон сууц барих ажлын гүйцэтгэгчээр “Жавхланхүслэн” ХХК шалгарч барилгын суурь хийгдсэн. Юнайтед хэрэйд ХХК өөрийн хөрөнгөөр 96 айлын орон сууц барих ажлыг 2024 оны 2 дугаар улиралд эхлүүлсэн бөгөөд 6 давхрын бетон цутгалтын ажил хийгдсэн. 2025 онд бүрэн ашиглалтад оруулна. Дүүргийн 1,2 дугаар хорооны 416 айлын орон сууцыг барихаар төлөвлөгөөнд тусган ажиллаж байна | 100 | 100 |
| **ТАВ. НИЙСЛЭЛ БА БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО (1 зорилт 1 арга хэмжээ)** | | | | | | | | | |
| 5.1 | | **Зорилт 5.1** Авто зам, нийтийн тээвэр /НЗДҮАХ 6.2.1.5, НХТЖҮЧ-6.4.1, 9.19.1, 9.19.2, 9.19.3, НЗДҮАХ 6.3, АХ-2.5.5, НЗДҮАХ-5.1.1, 5.1.2, ДЗДҮАХ 5.1.4, 5.2.2, 5.2.4, 6.2.3, 6.2.4, 6.2.5, 6.2.6, 6.2.7, 6.2.8, 6.2.9, 6.2.10, 6.5.3 / | - | Арга хэмжээний хэрэгжилт, дундаж хувь | 100 | 100 | Дүүргийн гол, туслах авто замын зорчих хэсгийн эвдрэл хагарлыг нөхөн, шинэчлэх ажилд 16 удаа хяналт тавьж ажиллав. | 100 | 100 |
| 46. | 5.1.1 | **Арга хэмжээ- 5.1.1** Нутаг дэвсгэрийн хэмжээнд авто замын уртыг нэмэгдүүлнэ. | 5.6 тэрбум | Арга хэмжээний хэрэгжилт, дундаж хувь | 100 | 100 | Дүүргийн авто зам засварын ажлын тендерийг Нийслэлийн авто замын хөгжлийн газраас зарлан ажлын гүйцэтгэгчээр “Эко эвсэг зам” ХХК шалгарч 1 дүгээр хорооны 4 дүгээр байрны хойд уулзвараас Эрүүл мэндийн төв хүртэл 500м$^2$ бетонон замыг асфальтаар хучих, төмөр замын гармаас 1 дүгээр хороо хүртэлх замын 350м$^2$ эвдрэлийг засварлах, 730м урт эвдэрсэн замын | 100 | 90 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хашлага солих ажлыг хуваарийн дагуу гүйцэтгэж дуусгахад 150,0 сая төгрөг зарцуулав. Дүүргийн 2 дугаар хорооны зам засварын ажил (төсөвт өртөг 1,5 тэрбум)-ын тендерт гүйцэтгэгчээр шалгарсан "Эко эвсэг зам" ХХК нь 2 км авто замын 4090ш хуучин хашлагыг хуулан авч, 2 дугаар хорооны цогцолбор байрнаас Замчны гэр хорооллын 1.3 км авто зам хүртэл 1км авто замд 2084ш хашлага, явган замын асфальтан хэсгийг солихдоо 1м-ийн урттай 18 см-ийн өргөнтэй том хашлагыг суурилуулав. Ажлын гүйцэтгэлд 13 удаа хяналт тавьж стандартын шаардлага хангаагүй замын хашлага болон бусад зөрчилүүдийг арилгах тухай ЗДТГ-ын 2024 оны 03/750, 07/792 дугаартай албан бичгийг тус тус хүргэн ажиллав. | | |
| **2 ДУГААР ХЭСЭГ**<br>**ЗУРГАА.ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ (1 зорилт 2 арга хэмжээ)** | | | | | | | | | |
| 6.1 | | **Зорилт 6.1** Дүүргийн нутгийн захиргааны байгууллагуудын харилцан мэдээлэл солилцох, дамжуулах, мэдээллээр хангах үйл ажиллагааг сайжруулна. /НЗДҮАХ-4.2.1, ХАХТ-4.2.1.1-/ | - | Арга хэмжээний хэрэгжилт, дундаж хувь | 70 | 90 ба түүнээс дээш хувь | Тайлангийн хугацаанд 22 удаагийн хурлыг зохион байгуулж, 250 үүрэг чиглэл өгөгдөн, хэрэгжилт 90%-тай байна. | 90 | 100 |
| 47. | 6.1.1 | **Арга хэмжээ - 6.1.1** Байгууллагуудын харилцан мэдээлэл солилцох, дамжуулах, мэдээллээр хангах үйл ажиллагааг цахимжуулна. | - | Зохион байгуулах арга хэмжээний тоо | 5 | 5 ба түүнээс дээш | 2024 оны 01 дүгээр сарын 08-ны өдрөөс 12 дугаар сарын 02-ний өдрийн хооронд зохион байгуулагдсан дүүргийн Удирдах ажилтны 22 удаагийн шуурхай зөвлөгөөнөөс өгөгдсөн нийт 250 үүрэг даалгаврыг bagakhangai.ub.gov.mn сайтад байршуулан, хэрэгжилтийг ханган ажиллалаа. Тус хугацаанд зохион байгуулагдсан нийслэлийн Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнөөс өгөгдсөн | 90 | 70 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | тус дүүрэгт хамааралтай нийт 203 үүрэг даалгаврыг bagakhangai.ub.gov.mn сайтад байршуулан ААНБ, олон нийтэд мэдээллэж, хэрэгжилтийг хангуулан ажилласан ба ННЗБ-уудын дотоод удирдлагын хяналтын цахим системийн Хяналт-шинжилгээ, үнэлгээ дэд цэсэнд нийт 132 үүргийн биелэлтийг тайлагнаж, системд байршуулаагүй үүрэг даалгаврын биелэлтийг ажил хариуцсан мэргэжилтний /UB ERP/ чатаар хүргүүлэн ажиллалаа. | | |
| **3 ДУГААР ХЭСЭГ.<br>ДОЛОО. ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ<br>ХУУЛИАР "ТУСГАЙЛАН ОЛГОСОН" ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ, ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ (1 зорилт 5 арга хэмжээ)** | | | | | | | | | |
| 7.1. | | **Зорилт 7.1**<br>Гүйцэтгэлийн хяналтыг сайжруулж, санхүүгийн сахилга хариуцлагыг дээшлүүлнэ /ДЗДҮАХ-4.1/ | - | Арга хэмжээний хэрэгжилт, дундаж хувь | 90 | 90 ба түүнээс дээш хувь | Төсвийн захирагчийн 2024 онд хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр 3177088.9 мянган төгрөгийг төсөвлөн батлуулж 441683.6 мян.төгрөгийн хэмнэлттэй ажиллалаа. Санхүүгийн сахилга хариуцлагыг сайжруулж, дотоод аудит, нийслэлийн аудит болон бусад шалгалтад хамрагдаж бүрэн хангалттай дүгнэлттэй гараад байна. | 100 | 100 |
| 48. | 7.1.1 | **Арга хэмжээ-7.1.1**<br>Гүйцэтгэлийн хяналт, иргэдэд хүрсэн төрийн үйлчилгээг сайжруулна. | - | Зохион байгуулах арга хэмжээний тоо | 5 | 5 ба түүнээс дээш | Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/727, А/728 дугаар захирамжийн хүрээнд хяналт шалгалтын ажлыг 4 удаа зохион байгуулан холбогдох чиг үүргийн хүрээнд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллав. Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/727 дугаар захирамжийн дагуу дүүргийн Засаг даргын 2024 оны А/62 дугаар захирамжаар 11 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулан хороодын ажилд дэмжлэг үзүүлэх, зөвлөн туслах ажлыг зохион байгууллаа. Тус ажлын хүрээнд удирдамжийн дагуу 19 шалгуур үзүүлэлтээр зөвлөн туслах ажлыг зохион байгуулан зөвлөмж чиглэлийг өгч ажиллав. | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/728 дугаар захирамжийн хүрээнд дүүргийн үйлдвэрлэлийн бүсэд үйл ажиллагаа явуулж буй 7 ХХК, барилга угсралтын үйл ажиллагаа явуулж байгаа “Адамант” ХХК, Ян сарьдаг оргил ХХК-дад 2024 оны 04, 11 дүгээр сард 2 удаа хяналт шалгалтыг зохион байгуулан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль, дүрмийн хэрэгжилт, хөдөлмөрийн аюулгүй байдал түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр илэрсэн зөрчилд газар дээр нь заавар зөвлөмж өгөв. Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газартай хамтран Хүнсний худалдааны газруудын төлөвлөгөөт хяналт шалгалтыг 2024 оны 05 дугаар сард зохион байгуулан, худалдаа үйлчилгээний 5 байгууллагад хяналт шалгалт хийж ажлын хэсгийн зүгээс эрсдэлийг үнэлж, дүгнэх, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах, таслан зогсоох, хүнсний аюулгүй байдлын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бууруулах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллав. | | |
| 49. | 7.1.2 | **Арга хэмжээ- 7.1.2** Төсвийн хөрөнгийг үр ашигтай төлөвлөн, зориулалтын дагуу хэмнэлттэй зарцуулж санхүүгийн сахилга хариуцлагыг дээшлүүлнэ. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 90 | 90 ба түүнээс дээш | Төсвийн захирагчийн 2024 онд хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр 3177088.9 мянган төгрөгийг төсөвлөн батлуулж 441683.6 мян.төгрөгийн хэмнэлттэй ажиллалаа. Санхүүгийн сахилга хариуцлагыг сайжруулж, дотоод аудит, нийслэлийн аудит болон бусад шалгалтад хамрагдаж бүрэн хангалттай дүгнэлттэй гараад байна. | 100 | 100 |
| **Засгийн газрын 2021 оны 350 дугаар тогтоол** | | | | | | | | | |
| 50. | | **Арга хэмжээ-** Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих ажлыг зохион | 2.0 | Зохион байгуулах ажил/тарих модын тоо | 2/3280 | 2/1000-аас дээш | “Бүх нийтээр мод тарих” ажлын нээлтийн арга хэмжээг дүүрэгт 2024 оны 05 дугаар сарын 09-ны өдөр зохион байгуулсан бөгөөд тус арга хэмжээнд 13 ААНБ –ын | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | байгуулна. | | | | | 136 ажилтан, албан хаагч оролцов. Тайлант хугацаанд 18 аж ахуйн нэгж, байгууллага, 24 өрхийн 346 ажилтан, албан хаагч, иргэн оролцож нийт 4 төрлийн 4920 ш мод бут, сөөг тарьж тус ажилд нийт 15.8 сая төгрөг зарцуулав. Намрын мод тариалалтын ажлаар дүүргийн мод бут тарих хүсэлт ирүүлсэн аж ахуйн нэгж, иргэдэд мод бут олгож заавар зөвлөгөө өгч хамтран ажиллалаа. Дээрх ажлын хүрээнд 1-р хорооны хамт олон 68ш гүйлс, 16ш үхрийн нүд, 60ш хайлаас, 2-р хороо 60ш хайлаас, 3ш монос, 3ш голт бор, Цагдаагийн хэлтэс 100ш хайлаас, 20ш гүйлс, Хангай цогцолбор сургууль 200ш хайлаас, ЗДТГ 200ш хайлаасыг байгууллагын хашаа хайсанд тарьж, намрын мод тариалалтаар Хайлаас-1500ш ,Мөнгөлөг улиас-90ш, Монос-50ш, Голт бор-30ш, Үхрийн нүд-100ш, Шар хайлаас-100ш, Шар хуйс-2030ш нийт 3900ш мод бут тарьж, 1-р хорооны 12 иргэн, 2-р хорооны 11 иргэн 151ш үхрийн нүд, 78ш гүйлсний суулгац 109 өрхөд чимэглэлийн, гоёлын, жимсний, навчит гээд нийт 1596 ширхэг мод олгож нийт 7000 ширхэг мод бутыг цэнэг усалгаа нөхөн тарилтыг хийж гүйцэтгэлээ. | | |
| **Монгол Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоол** | | | | | | | | | |
| 51. | | **Арга хэмжээ-** Хүнсний хангамж аюулгүй байдал үндэсний хөдөлгөөнийг хангаж ажиллана. | - | Төлөвлөгөө гаргах | 1 | 1 | Хаврын тариалалтыг дэмжих бодлогын хүрээнд хүнсний нарийн ногоо тариалах хүсэлтэй иргэдэд дэмжлэг үзүүлэхээр 7 төрлийн хүнсний нарийн ногоо үр НХААГ-аас авч 1,2-р хорооны ажлын хэсэгт хүлээлгэн өгсөн бөгөөд 1 ААНБ болон 1 дүгээр хорооны 18 өрх, 2 дугаар хорооны 23 өрх, нийт 41 айл өрх төмс, хүнсний ногоо тариалаад байна. Тус арга хэмжээнд дүүргийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 703,520 төгрөг зарцуулав. 20 хаврын | 90 | 70 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | тариалалтын явцын мэдээг 05 дугаар сарын 29-нөөсс 06 дугаар сарын 29 хүртэл хугацаанд 7 хоног бүрийн мягмар, баасан гарагт хавсралт хүснэгтийн дагуу холбогдох мэргэжилтэнд хүргэн ажиллаж байна. “Алтан намар-2024” үзэсгэлэн худалдаа 08 дугаар сарын 29-30ны өдөр 1-р хорооны төв талбайд зохион байгуулж цагаан идээ, төмс, хүнсний ногоо тариалдаг 3 иргэн 13 төрлийн ногоог худалдан борлуулж 6,3 сая төгрөгийн борлуулалт хийгдсэн байна. | | |
| **Засгийн газрын 2022 оны 419 дүгээр тогтоол** | | | | | | | | | |
| 52. | | **Арга хэмжээ-** Засгийн газрын 2022 оны 419 дүгээр тогтоолын 4-р (Улаанбаатар хотын хэт төвлөрлийг бууруулах, хот, хөдөөгийн хөгжлийн зохистой тэнцвэрийг хангах зорилгоор Багахангай дүүргийн хүн амыг 20 хувиар нэмэгдүүлэх )заалтын хэрэгжилтийг хангана. | - | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 5 | 5 | “Хот хөдөөгийн сэргэлт”-ийн бодлогын хэрэгжилтийг хангах ажлын хэсэг байгуулагдсан. Тайлангийн хугацаанд 12 арга хэмжээ зохион байгуулав. Тогтоол гарсан 2022 оны 11 дүгээр сараас 2024 оны 09 дүгээр сарын 28-ний өдрийн хооронд Улаанбаатар хот болон бусад орон нутгаас Багахангай дүүрэгт нийт 389 иргэн шилжин суурьшиж 253 иргэн тус дүүргээс өөр аймаг орон нутаг руу шилжсэн тус дүүрэгт 171 иргэн шилжиж ирсэн. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх, дүүргийн төсвийн орлого, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор Янь сарьдаг оргил ХХК, Сарьдаг хангайн оргил ХХК, Тен фрейт лайн ХХК, Эл эс рэйлвэй ХХК – иудад дүүрэгт шилжин ирж үйл ажиллагаа явуулах хүсэлтийг албан бичгээр өгсөн.<br>Дүүргийн өмчид бүртгэлтэй “Төрийн албан хаагч”-ийн 15 байранд нийт 42 төрийн албан хаагчийг түр орон сууцаар хангасан. 2023 оны жилийн эцсийн статистик мэдээгээр дүүрэгт нийт 4422 хүн тоологдсон ба 2024 оны 12 дугаар сарын | 100 | 70 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 05-ны өдрийн байдлаар нийт 4591 иргэн байна. | | |
| **НАЙМ“ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ” ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ ( 1 зорилт 1 арга хэмжээ )** | | | | | | | | | |
| 8.1 | | **Зорилт-8.1** Үйл ажиллагааны гүйцэтгэлийн хяналтыг сайжруулна. / ДЗДҮАХ-4.1, НХТЖҮЧ-2.5.1, ХАХТ-2.1.1.1/ | - | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь<br><br>Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 90<br><br>5 | 90 ба түүнээс дээш хувь<br><br>5 ба түүнээс дээш | Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/727 дугаар захирамжийн дагуу дүүргийн Засаг даргын 2024 оны А/62 дугаар захирамжаар 11 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулан хороодын ажилд дэмжлэг үзүүлэх, зөвлөн туслах ажлыг зохион байгууллаа. Тус ажлын хүрээнд удирдамжийн дагуу 19 шалгуур үзүүлэлтээр зөвлөн туслах ажлыг зохион байгуулан зөвлөмж чиглэлийг өгч ажиллав. Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/728 дугаар захирамжийн хүрээнд дүүргийн үйлдвэрлэлийн бүсэд үйл ажиллагаа явуулж буй 7 ХХК, барилга угсралтын үйл ажиллагаа явуулж байгаа “Адамант” ХХК, Ян сарьдаг оргил ХХК-дад 2024 оны 04, 11 дүгээр сард 2 удаа хяналт шалгалтыг зохион байгуулан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль, дүрмийн хэрэгжилт, хөдөлмөрийн аюулгүй байдал түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр илэрсэн зөрчилд газар дээр нь заавар зөвлөмж өгөв. Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газартай хамтран Хүнсний худалдааны газруудын төлөвлөгөөт хяналт шалгалтыг 2024 оны 05 дугаар сард зохион байгуулан, худалдаа үйлчилгээний 5 байгууллагад хяналт шалгалт хийж ажлын хэсгийн зүгээс эрсдэлийг үнэлж, дүгнэх, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах, таслан зогсоох, хүнсний аюулгүй байдлын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бууруулах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллав. | 90 | 100 |
| 53. | 8.1.1 | **Арга хэмжээ-8.1.1** Гүйцэтгэлийн үнэлэн | - | Үйл ажиллагаан | 90 | 90 ба түүнээс | 2024 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр 28 зорилт 178 арга хэмжээ бүхий | 90 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | дүгнэн, сахилга хариуцлагыг дээшлүүлж, дотоод үйл ажиллагааг сайжруулна. | | ы хэрэгжилт, хувь | | дээш | байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулан тайлангийн хугацаант хэрэгжилт 95.3 үнэлэгдлээ. Тамгын газрын даргын 2024 оны А/19 дүгээр тушаалаар байгуулан албан хаагчдын гүйцэтгэлийн тайланг үнэлж дүгнэх үнэлгээний багийг байгуулан 2024 оны 1,2 дугаар улирлын тайланг 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр дүгнэх ажлыг зохион байгуулан 45 албан хаагчид маш сайн үнэлэгдлээ. 3,4 дүгээр улирлын гүйцэтгэлийн үнэлгээг 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. | | |
| 8.2 | | **Зорилт 8.2**<br>Байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ. | - | Үйл ажиллагаан ы хэрэгжилт, хувь | - | 100% | - Тайлангийн хугацаант нийт 90 өргөдөл, гомдол иргэдээс ирүүлсэн байна. Шийдвэрлэлтийн хувь 98,8% байна.<br>- 2023 онд баталсан хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу байнга хадгалах 128, түр хадгалах 234, 70 жил хадгалах 25, тусгай төрлийн 38, нийт 425 хадгаламжийн нэгж бүхий баримтуудын бүртгэлийг үйлдэж дүүргийн төрөлжсөн архивт хүлээлгэн өгөв.<br>- Засаг даргын Тамгын газрын хурлыг хуваарийн дагуу Тамгын газрын хурлыг 10 удаа, хэлтсийн дарга нарын хурлыг 4 удаа зохион байгуулан 168 үүрэг чиглэлийг хэлтэс, хороодод хүргүүлэн, 92%-ийн хэрэгжилттэй байна.<br>- Байгууллагын болон бусад байгууллагаас зохион байгуулсан тэмцээн уралдаан, соёл урлаг, олон нийтийн арга хэмжээнд давхардсан 362 албан хаагчийг хамруулаад байна.<br>- Bagakhangai.ub.gov.mn сайтад нийт 269 мэдээ мэдээлэл, 28 шторк, шилэн дансанд 149 захирамж 53 тушаал, “Багахангайн мэдээ” группэд Нийслэл болон дүүргээс хэрэгжүүлж буй үйл | 90 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ажиллагаа, бодлого шийдвэр, цаг үеийн холбогдолтой 280 мэдээ, мэдээлэл, 42 видео контент бэлтгэн байршуулсан. | | |
| 56 | 8.2.1 | **Арга хэмжээ – 8.2.1** Байгууллагад чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлэх | - | Үйл ажиллагаан ы хэрэгжилт, хувь | 2 ба түүнээс дээш | 2 ба түүнээс дээш | Чанарын менежментийн тогтолцооны стандартын сайжруулалтын ажлыг албан хаагчдад хуваарилан Засаг даргын Тамгын газрын “Мэдээллийн цаг” арга хэмжээнд танилцуулав.СХД-ийн ЗДТГ-ын хууль зүйн хэлтэстэй хамтран “Чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх арга зүй”-н сургалт 1, “Глобал куалити” аудитын ХХК-тай хамтран байгууллагын чанарын менежментийн тогтолцооны баталгаажуулалтын хөндлөнгийн аудитыг хийж зөвлөгөө, зөвлөмж, хугацаатай үүрэг даалгавар өгөн ажиллав. Үүрэг чиглэлийн дагуу албан хаагчдын чадамжийн түвшин тодорхойлох удирдамж 1, холбогдох чиг үүргийн 8 журам, 2 хөтөлбөр, 1 зураглалыг боловсруулан батлуулж 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр “Глобал куалити” аудитын ХХК-д хүргүүлээд байна. MNS ISO9001:2015 чанарын менежментийн тогтолцооны стандартыг нэвтрүүлсэн гэрчилгээг ЗГХЭГ-аас 2024.12.16-нд гардан авна. | 100 | 90 |
| 57 | 8.2.2 | **Арга хэмжээ – 8.2.2** Албан тушаалынхаа чиг үүргийн хүрээнд иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж, хариуг иргэнд хууль эрх зүйн үндэслэлтэйгээр өгөх, өргөдөл шийдвэрлэх явцад зөрчил гаргахгүй ажиллах | - | Албан бичгээр хариу өгсөн өргөдлтйн тоо | 3 ба түүнээс дээш | 3 ба түүнээс дээш | Тайлангийн хугацаанд хэлтсийн албан хаагчдад нийт 90 өргөдөл, гомдол иргэдээс ирүүлсэн байна. Шийдвэрлэлтийн хувь 98,8% дундаж хоног 7 хоног 0 цаг 37 минут байна. Өргөдлийн шийдвэрлэлтэд тухай бүр хяналт тавьж, 2024 оны 3 дугаар улирлын байдлаар 3 иргэнд хариуг албан бичгээр, 84 иргэнтэй биеэр уулзаж, 2 иргэнд утсаар хариуг тус тус өгөөд байна. | 100 | 100 |
| 58 | 8.2.3 | **Арга хэмжээ – 8.2.3** | - | Зохион | 5 ба | 5 ба | Тайлангийн хугацаанд дараах арга | 90 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Байгууллагын болон бусад байгууллагаас зохион байгуулсан тэмцээн уралдаан, соёл урлаг, олон нийтийн арга хэмжээнд оролцох | | байгуулсан арга хэмжээний тоо | түүнээс дээш | түүнээс дээш | хэмжээнүүдэд албан хаагчдыг хамруулсан байна. Үүнд : “2024 - Өвлийн өдөрлөг” арга хэмжээ 2024.02.02 өдөр 35 албан хаагч, “Эрүүл чийрэг спортлог -Эртэч Багахангайчууд” аян 2024.02.26-28 хооронд давхардсан тоогоор 45 албан хаагч, “Дасгал хийж хамтдаа хөгжье аян”-д 2024.03.13,20 хооронд давхардсан тоогоор 63 албан хаагч, “Хүн амын бие бялдрын түвшин тогтоох сорил”-д 2024 оны 03 дугаар сарын 14-ний өдөр 38 албан хаагч, Багахангай дүүрэг үүсэн байгуулагдсаны 35 жилийн ойн хүрээнд зохион байгуулсан дүүргийн аварга шалгаруулах “Сагсан бөмбөг”, Волейболын тэмцээнүүдэд 2024 оны 03 дугаар сарын 22,30-н өдрүүдэд эрэгтэй, эмэгтэй баг тамирчид амжилттай оролцсон. Багахангай дүүрэг үүсэн байгуулагдсаны 35 жилийн ойн хүрээнд зохион байгуулсан Урлагийн наадамд 2024.04.26-нд 39 албан хаагч, “Багахангай марафон”-д 2024 оны 05 дугаар сарын 03-нд 6 албан хаагч, “Эрүүл, идэвхтэй багахангайчууд”-2024 явган алхалтын арга хэмжээнд 2024.05.13-20 өдрүүдэд давхардсан тоогоор 84 албан хаагч, Нийслэлийн иргэдийн спортын XII наадмын Сагсан бөмбөг, Волейбол, Шаагай наадгай гэсэн төрлүүдэд давхардсан тоогоор 95 албан хаагч нийт 2024 онд 12 арга хэмжээнд давхардсан 362 албан хаагчдыг олон нийтийн арга хэмжээнд оролцуулах ажлыг зохион байгуулсан байна. | | |
| 59 | 8.2.4 | **Арга хэмжээ – 8.2.4** Засаг даргын Тамгын газрын хурлын биелэлтийг цаг хугацаанд нь чанартай | - | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 5 ба түүнээс дээш | 5 ба түүнээс дээш | Засаг даргын Тамгын газрын хурлыг хуваарын дагуу Тамгын газрын хурлыг 10 удаа, хэлтсийн дарга нарын хурлыг 4 удаа зохион байгуулан 178 үүрэг чиглэлийг хэлтэс, хороодод хүргүүлэн, 92%-ийн | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | гарган ирүүлэх | | | | | хэрэгжилттэй байна. | | |
| 60 | 8.2.5 | **Арга хэмжээ – 8.2.5** Албан тушаалынхаа чиг үүргийн хүрээнд хүрээнд зохион байгуулсан арга хэмжээний мэдээллийг "Багахангайн мэдээ" Facebook хуудсанд өдөрт нь байршуулах | - | Байршуулсан арга хэмжээний тоо | 2 ба түүнээс дээш | 2 ба түүнээс дээш | Тайлангийн хугацаанд "Багахангайн мэдээ" группэд Нийслэл болон дүүргээс хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, бодлого шийдвэр, цаг үеийн холбогдолтой 280 мэдээ, мэдээлэл, 42 видео контент бэлтгэн байршуулж, иргэд олон нийтэд хүргэн ажиллалаа. | 90 | 100 |
| 61 | 8.2.6 | **Арга хэмжээ – 8.2.6** Архивын бичиг баримтыг заагдсан хугацаанд стандартын дагуу хүлээлгэн өгөх | - | Хэрэгжилтийн хувь | - | 100% | 2023 онд баталсан хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу байнга хадгалах 128, түр хадгалах 234, 70 жил хадгалах 25, тусгай төрлийн 38, нийт 425 хадгаламжийн нэгж бүхий баримтуудын бүртгэлийг үйлдэж дүүргийн төрөлжсөн архивт хүлээлгэн өгөв. 2024 онд үүсэн архивын баримтын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг Архивын ерөнхий газрын даргын 2023 оны "Архивын баримтын нэр төрөл, хадгалах хугацааны үлгэрчилсэн болон салбарын жагсаалт батлах тухай" А/91 дүгээр тушаалаар батлагдсан жагсаалтын дагуу хадгалах хугацаа зүйлийн дугаарыг тодорхойлж, байнга хадгалах 105, түр хадгалах 83, 70 жил хадгалах 6, нийт 196 хадгаламжийн нэгж үүсэхээр батлав. | 100 | 100 |
| 62 | 8.2.7 | **Арга хэмжээ – 8.2.7** Албан тушаалынхаа чиг үүргийн хүрээнд хүрээнд зохион байгуулсан арга хэмжээнийхээ мэдээллийг дүүргийн веб сайтад хуулийн хугацаанд байршуулах. | - | Байршуулсан арга хэмжээний тоо | 2 ба түүнээс дээш | 2 ба түүнээс дээш | Bagakhangai.ub.gov.mn сайтад нийт 269 мэдээ мэдээлэл, 28 шторк, шилэн дансанд 149 захирамж 53 тушаалыг хуулийн хугацаанд байршуулан иргэд олон нийтэд хүргэж ажиллав. | 100 | 100 |
| 63 | 8.2.8 | **Арга хэмжээ – 8.2.8** Ёс зүйн зөрчилгүй ажиллана. | - | Хэрэгжилтийн хувь | - | 100% | Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны А/58 дугаар тушаалаар Байгууллагын ёс зүйн дэд хороог 5 хүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулж, Ёс зүйн дэд хорооны төлөвлөгөөг боловсруулан дэгийг | 90 | 70 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | батлууллаа. Ёс зүйн дэд хороо нь албан хаагчийн ирүүлсэн гомдол, мэдээллийн дагуу 5 удаа хуралдаж, 5 дүгнэлт, 1 зөвлөмж гаргасан. Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүд, нарийн бичигт хуралд оролцсон байдал, арга хэмжээ, ирц, идэвхийг харгалзан үзсэний үндсэн дээр 2-р улирлын болон 5,6,7,8-р сарын урамшууллыг олгон ажиллав. “Төрийн албан хаагчийн ёс зүй, гадаад дүр төрх” сургалт 2024 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр зохион байгуулан 45 албан хаагчийг хамруулллаа. Ёс зүйн зөрчил гаргасан 1 албан хаагчид ёс зүйн хариуцлага тооцсон байна. Ёс зүйн дэд хорооны тайлан мэдээг маягтын дагуу гарган холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлэн ажиллав. | | |
| **Дундаж** | | | | | | | | **96.3%** | **95.2%** |

ТӨЛӨВЛӨГӨӨ ХЯНАСАН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ

ЗАСАГ ДАРГА .... .................... (А.СҮХБОЛД)

2024 оны ..... дугаар сарын ..........өдөр

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН

ЭРХ ЗҮЙ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ХӨРӨНГӨ ОРЛОГЫН МЭДҮҮЛЭГ

ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Н.БАТЦЭНГЭЛ

2024 оны ..... дугаар сарын ..........өдөр

ТӨЛӨВЛӨГӨӨ ТАЙЛАГНАСАН ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА .. ...................... (Л.САНЖИЙЖАМЦ)

2024 оны ..... дугаар сарын ..........өдөр